



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

“УС-ДУ” ОНӨААТҮГ-ын 2016-2017 оны
үйл ажиллагааны үр дүн



**ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ ХИЙН, БОЛОВСОН ХУЧИН, ХҮНИЙ
НӨӨЦИЙН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЖ, ҮНЭ ТАРИФЫГ ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭНД
НЭМЭГДҮҮЛЭН, САНХҮҮГИЙН САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛСНЭЭР
БАЙГУУЛЛАГА ҮР АШИГТАЙ АЖИЛЛАХ БОЛОМЖТОЙ БАЙНА.**

2018 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар..... 4 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй..... 5
Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар	Бүлэг 1: Байгууллага үндсэн чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд орон нутгийн болон байгууллагын түвшинд баримтлах бодлогын баримт бичиг шаардлагатай байна.
Дарга, Тэргүүлэх аудитор	1.1 Орон нутгийн болон байгууллагын түвшинд баримтлах бодлогын баримт бичиг байхгүйгээс байгууллага үндсэн чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлж чадахгүй байна.
Б.Сарантуяа	1.2 Бүтэц, орон тоо нь хуулийн хүрээнд зохион байгуулагдаагүй байна.
Аудитын менежер	1.3 Хүний нөөцийн бодлого төлөвлөлт хангалтгүй, мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, ажиллагсдын ажлын гүйцэтгэлийг сайжруулах шаардлагатай байна.
Г.Наранбаяр	1.4 Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанаас 2016, 2017 онд 146,701.0 мянган төгрөгийн ашигтай ажиллажээ.
Аудитор	Бүлэг 2: Үйл ажиллагааны орлого, зардлыг бодитой төлөвлөөгүй, үнэн зөв бүртгэж тайлагнаагүй, мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул, үнэ тарифыг зохистой хэмжээнд шинэчлэн батлуулах шаардлагатай байна.
Б.Дарханбат	2.1. Үндсэн үйл ажиллагааны орлого, зардлыг тендер шалгаруулалтын орлогоос хамааруулан нэмэгдүүлж төлөвлөсөн нь бодит байдалтай нийцэхгүй байна.
М.Ундармаа	2.2. Орлогын төлөвлөгөөг 2017 онд 19.5%-иар дутуу биелүүлсэн, НББ-ийн тухай хуульд заасны дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй байна.
Б.Анхтуяа	2.3. Дараа тайлангаар бэлнээр олгож буй мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул, бэлэн мөнгөний зарцуулалтад хяналт тавих эрх бүхий этгээдүүд хөрөнгө бэлтгэсэн байна.
2018 оны 05 дугаар сар	2.4. Үнэ тарифыг үйлдвэрлэлийн өртөгтэй уялдуулж зохистой хэмжээнд шинэчлэх шаардлагатай байна.
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543151 дугаарын утсаар харилцана уу.	2.5. Өглөг, авлагыг үнэн зөв бүртгэж тайлагнаагүй байна.

ХАЯГ:

Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 209 тоот

Бүлэг 3: Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулаагүй, хөрөнгийн дансны ангиллыг буруу бүртгэж тайлагнасан байна.

- 3.1. Хөрөнгө, бараа материалын худалдан авалтыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.
- 3.2. Хөрөнгийн дансны ангиллыг буруу бүртгэж тайлагнасан байна.
- 3.3. Өмч хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлэх, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.

Бүлэг 4: Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй, хяналтын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

- 4.1. Байгууллагын удирдлага дотоод хяналтын үүргээ хэрэгжүүлээгүй байна.
- 4.2. Дотоод хяналт үр дүнгүй байна.
- 4.3. Бусад байгууллагаас хийгдсэн хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.
- 4.4. Шилэн дансны цахим системд оруулсан мэдээний 61.5% нь хугацаа хоцорсон мэдээлэл байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын саналд хийсэн тайлбар

Хавсралтууд

Товчилсон үгийн тайлбар

ГСА	Говьсүмбэр аймаг
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НААУ	Нийтийн аж ахуй үйлчилгээ
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
БХБ	Барилга хот байгуулалт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжил сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УОО	Урьдчилж орсон орлого
ААХ	Ажилчин албан хаагч
БУЗ	Борлуулалт удирдлагын зардал
ҮХДХГ	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Ерөнхий аудиторт Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт:

Аймгийн “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2016-2017 оны үйл ажиллагааны үр дүнд Гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

3. Аудитын хамарсан хүрээ:

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2016-2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон санхүүгийн тайлан, бүртгэл тайлагнал, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой анхан шатны баримтууд, холбогдох бусад материалуудыг хамруулан, мэдээ, судалгаанд тулгуурлан аудитыг хийж гүйцэтгэлээ.

4. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн болон Санхүүгийн аудитын журмыг ашиглан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, тулган баталгаажуулах зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ, аудитын судалгаа хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

1. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, аудитын менежер Г.Наранбаяр үе шатны хяналтыг хийж, аудитор Б.Дарханбат, М.Ундармаа, Б.Анхтуяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Хүндрэл бэрхшээл

Аудитын явцад харилцагч байгууллагын ажилтнууд шаардлагатай мэдээ судалгааг цаг хугацаанд нь гаргаж ирүүлээгүй, ирүүлж буй мэдээ, судалгааны дүн зөрүүтэй, анхан шатны баримтын эмх цэгц хангалтгүй байдал нь хүндрэл бэрхшээл учруулж байлаа.

8. Үндсэн мэдээлэл

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь Эрчим хүчний сайдын 1991.07.20-ны өдрийн 117 дугаар тушаалаар Чойрын Эрчим хүчний үйлдвэр нэртэйгээр Улаанбаатар хотын төвийн эрчим хүчний системийн харъяанд байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба 1996 оноос БХБ-ын яаманд харъяалагдан НААҮ-ний “Ус-Ду” ОНӨААТҮГ нэртэйгээр дулаан үйлдвэрлэн, цэвэр ус олборлон түгээх, бохир ус татах, зайлуулах, шугам хоолойн засвар үйлчилгээг дуудлагаар засварлах зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

НААҮ-ний “Ус-Ду” ОНӨААТҮГ нь 2016 онд 1,289,304.4 мянган төгрөгийн орлого, 1,159,121.4 мянган төгрөгийн зардал төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 1,766,231.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,599,876.5 мянган төгрөгийг зарцуулан 166,355.1 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. 2016 оны жилийн эцсийн байдлаар 73,625.2 мянган төгрөгийн авлага, 82,953.1 мянган төгрөгийн бараа материал, 2,268,779.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 110,964.6 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнасан байна.

2017 оны байдлаар 1,789,881.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,738,963.9 мянган төгрөг зарцуулж, 50,918.0 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн ба тайлант онд 1,440,155.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,852,544.6 мянган төгрөгийг зарцуулж (412,389.6) мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар 103,396.3 мянган төгрөгийн авлага, 137,647.5 мянган төгрөгийн өглөг, 84,103.6 мянган төгрөгийн бараа материал, 3,242,788.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

2016, 2017 онуудын санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан байна.

Аймгийн ЗДТГ-аас 2016 онд тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 78.7%-иар үнэлжээ.

2017 онд Говьсүмбэр аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан боловч гэрээний биелэлтээ дүгнүүлээгүй байна.

Бүлэг 1

Байгууллага үндсэн чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд орон нутгийн болон байгууллагын түвшинд баримтлах бодлогын баримт бичиг шаардлагатай байна.

1.1 Орон нутгийн болон байгууллагын түвшинд баримтлах бодлогын баримт бичиг байхгүйгээс байгууллага үндсэн чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлж чадахгүй байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь 1991 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 2004 онд компанийн дүрмийг аймгийн Засаг даргын 25 дугаар захирамжаар баталсан байна. Компанийн дүрмийг баталж, дүрэмд заасны дагуу Удирдах зөвлөлийг аймгийн Засаг дарга томилох, компанийн захирлыг удирдах зөвлөлийн санал болгосноор аймгийн Засаг дарга томилох гэсэн заалтуудыг тодорхой тусгаж өгсөн боловч удирдах зөвлөлийн үйл ажиллагааг тодорхойлсон заалтууд хэрэгжээгүй байна.

2016 онд байгууллагын удирдлагатай гэрээ байгуулаагүй, үйл ажиллагаа, санхүү, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үр ашгийн төлөвлөгөөг батлаагүй, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна.

2017 онд аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан боловч гэрээний биелэлтийг дүгнээгүй, төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөөгүй байна.

Тус байгууллагын нийт хэрэглэгчийн 75%-ийг 1,119 айл өрх эзэлж байгаа боловч 7 айл өрхтэй гэрээ байгуулаагүй, 67 айл өрхийн гэрээг сунгаагүй, хэрэглэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж ажиллаагүй, айл өрхийн халаалтын талбайг бодитой тооцож гаргаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.3, 77 дугаар зүйлийн 77.2, Засгийн газрын 2001 оны “Дүрэм батлах тухай” 263 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3, 22, 24, 25, 45 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын дүрэмд байгууллагын үндсэн эрхлэх үйл ажиллагааг дараах чиглэлээр баталсан байна. Үүнд:

- Цэвэр ус олборлох, хэрэглэгчдэд чанарын шаардлага хангасан цэвэр ус түгээх
- Стандартын шаардлага хангасан дулааны эрчим хүчээр хэрэглэгчдийг хангах
- Хэрэглээний халуун ус бэлдэж хэрэглэгчдэд түгээх
- Бохир усанд анхан шатны цэвэрлэгээ хийж зайлуулах
- Хэрэглэгчдийн захиалгын дагуу засвар үйлчилгээг мөрдөгдөж буй тарифын дагуу чанартай хийж гүйцэтгэх
- Компани нь өөрийн байгууллагын чадварын хүрээнд хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагааг эрхэлж болно.

Компанийн дүрэмд заасан үйл ажиллагааг явуулахдаа захиргаа, борлуулалт, ус хангамж, дулаан, хэрэглээ гэсэн 5 хэсгээр зохион байгуулж, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2013 оны №00031, аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 01/2014, Барилга хот байгуулалтын яамны 2017 оны №БУ-593/17, Стандартчлал хэмжил зүйн газрын 2016 оны №3 тоот тусгай зөвшөөрлөөр тус тус гүйцэтгэж байна.

Цэвэр ус олборлох, түгээх үйл ажиллагаа :

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь гүний 2 худаг, 500м³-ийн багтаамжтай 2 усан сан, ус цэвэршүүлэх төхөөрөмж, цэвэр усны насос станц, 8.3 км цэвэр усны шугам хоолойгоор дамжуулан газрын гүний усыг хэрэглэгчдэд түгээж байна.

Цэвэр ус олборлох үйл ажиллагааг одоогийн байдлаар 2 гүний худгаар явуулж байгаа бөгөөд тус байгууллагын данс бүртгэлд цэвэр усны 4 худаг бүртгэлтэй боловч 2 худаг нь шугам сүлжээгээр холбогдоогүй, яаралтай үед нөөц байдлаар шууд ашиглах боломжгүй байна.

Тус байгууллагын 2016-2017 онд олборлож, түгээсэн цэвэр усны хэмжээг хүснэгтээр харуулбал:

Он	Олборлосон /м3/	Түгээсэн /м3/		
		Хэрэглээний халуун ус	Цэвэр ус	Дотоод хэрэглээ
2017	115,800	79,820	30,130	5,850
2016	116,500	83,660	26,690	6,150

Хүснэгтээс харахад: Цэвэр ус олборлолтын хэмжээ 2017 онд өмнөх оноос 0.7%-иар буурсан нь халуун усны хэрэглээтэй холбоотой байна. Нийт олборлосон цэвэр усны 68.9-71.8 хувийг хэрэглээний халуун ус түгээхэд зарцуулсан байна.

Жил бүр цэвэр ус олборлох, түгээх үйлдвэрлэлийн төлөвлөгөөг эрх бүхий этгээдээр батлуулан мөрдөж ажиллаагүй тул “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын ирүүлсэн төлөвлөлтийг авч үзэв.

Цэвэр ус түгээх үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	2017 он			2016 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Цэвэр ус	м3	69,748	79,820	114%	70,200	83,660	119%

Хүснэгтээс харахад: Ус түгээх үйл ажиллагаа төлөвлөснөөс жил бүр 14-19%-иар давсан нь нийтийн эзэмшлийн гудамж талбайн мод зүлэг услалт, айл өрхийн хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын усан сангийн нөөцийн багтаамж 1000м³ бөгөөд Найрамдал хотхоны ундны усны хоногийн хэрэгцээ 250-300м³ байна. Одоогийн ашиглаж буй усан

сангийн нөөцийн багтаамж нь Найрамдал хотхоны 2-3 хоногийн усны хэрэгцээг нөөцлөхөөр байна.

Иймд өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахад шинээр нөөц усан сан байгуулах шаардлага тулгарч байна.


Тус байгууллага нь хэрэглэгчдийг ундны усаар хангаж байгаа боловч усны чанар холбогдох стандартад нийцэхгүй байна. Төмөргүйжүүлэх төхөөрөмж 2005 оноос хойш ашиглагдаж байгаа боловч ашиглалтын хугацаа дууссан, зориулалтын бодисгүйн улмаас бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй, хэрэгцээ шаардлага хангахгүй болсон байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2014 онд “Ундны усны чанар, аюулгүй байдал”-ын талаар бүх аймгийн Засаг дарга нарт зөвлөмж гаргасан бөгөөд сум суурин газрын 856 худгийг хамруулсан шинжилгээгээр ундны цэвэр усан дахь төмөр болон бусад химийн элементүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү илэрчээ.

Тухайлбал: “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын худгаас түгээж буй ундны усан дахь магни зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 13.6%-иар их гарсан тул худгийн төмөргүйжүүлэх төхөөрөмжийг шинэчлэх, ундны усны чанарт тавигдах дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өгөгджээ. Зөвлөмжийн мөрөөр тодорхой үр дүнтэй ажил хийгдээгүй байна.

Ундны усанд хийсэн шинжилгээгээр усанд агуулагдаж буй төмрийн хэмжээг графикаар харуулбал:

Ундны усанд агуулагдаж буй төмрийн хэмжээ



Графикаас харахад: 2015-2018 онуудад жил бүр тодорхой хугацаанд ундны усанд шинжилгээ хийхэд төмөргүйжүүлэх төхөөрөмжөөр дамжуулсан усанд төмрийн хэмжээ харилцан адилгүй илэрсэн байна. Энэ нь уг төхөөрөмж усыг бүрэн цэвэршүүлж чадахгүй байгааг харуулж байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 13 дугаар зорилтын 47-д “Аймаг, сумдын төвийн усан хангамжийн эх үүсвэрт усны чанар сайжруулах, халдваргүйжүүлэх төхөөрөмж суурилуулна” гэж заасан бөгөөд одоогийн байдлаар хэрэгжээгүй байна.

Дулааны эрчим хүчээр хангах үйл ажиллагаа:

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь уурын зуухны суурилагдсан хүчин чадал, бодит ачааллыг үндэслэн дулаан үйлдвэрлэлийн төлөвлөгөөг батлуулж ажиллаагүй байна. 2016-2017 онд DZL 2.8 маркийн хүчин чадал бүхий 3, DZL 4.2 маркийн хүчин чадал бүхий 1, нийт 4 уурын зуухаар 12.6 мвт суурилагдсан хүчин чадалтай үйл ажиллагаагаа явуулжээ.

Тус байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй DZL 2.8 маркийн 3 уурын зуух нь 2006 онд, DZL 4.2 маркийн 1 уурын зуух нь 2011 онд тус тус ашиглалтанд орсон бөгөөд 1.5 км халаалтын шугамаар дамжуулан Найрамдал хотхоны 1,119 айл өрх, 64 аж ахуйн нэгжийг дулаанаар хангаж байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 14 дүгээр зорилтын 54-т “Аймаг, сумдын дулаан хангамжийн зуухны хүчин чадлыг нэмэгдүүлнэ” гэж заасны дагуу 2017 оны 12 дугаар сард улсын төсвийн хөрөнгө оруулалтаар DZL 7.0 маркийн 2 уурын зуухыг шинээр суурилуулсан бөгөөд угсралтын ажил дуусаагүй, улсын комисс хүлээн аваагүй байхад дулаан үйлдвэрлэлд ашиглажээ.

Энэ нь хуучин уурын зуухнууд ашиглалтын хугацаа дууссан, дулаан үйлдвэрлэлийн шаардлага хангахгүй, байнга эвдрэл гэмтэл гарч хөлдөлт үүсэх эрсдэл тулгарсантай холбоотой байна.

Тус байгууллагын дулааны хүчин чадал, бодит ачааллын судалгааг хүснэгтээр харуулбал:

Суурилагдсан хүчин чадал, бодит ачаалал						
Он	2017	2016	2015	2014	2013	2012
Халаалтын тогооны суурилагдсан хүчин чадал Мвт	12.6	12.6	12.6	12.6	12.6	12.6
Дулааны бодит ачаалал Мвт	11.2	11.2	11.1	11.1	11.0	10.6

Хүснэгтээс харахад: Сүүлийн 6 жилийн хугацаанд суурилагдсан хүчин чадал болон дулааны бодит ачаалалд өөрчлөлт ороогүй байна. Энэ нь тоног төхөөрөмж, технологийн шинэчлэл хийгдээгүйг харуулж байна.

2016-2017 онд үйлдвэрлэсэн дулааны хэмжээг хүснэгтээр харуулбал:

Он	2017			2016			
Үйлдвэрлэл үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Үйлдвэрлэвэл зохих	Гүйцэтгэл	Хувь	Үйлдвэрлэвэл зохих	Гүйцэтгэл	Хувь
Дулаан	Гкал	64,848	52,458	80%	63,504	50,938	80%

Хүснэгтээс харахад: 2016-2017 онд үйлдвэрлэвэл зохих дулааны 80%-ийг үйлдвэрлэсэн гэсэн үзүүлэлттэй байна. Энэ нь уурын зуухны дулаан үйлдвэрлэх хүчин чадлаас шууд хамаарч байна.

2017 онд үйлдвэрлэсэн дулаан өмнөх оноос 1,520 гкал буюу 2.9%-иар өссөн байна. Энэ нь 2017 оны 12 дугаар сард улсын төсвийн хөрөнгө оруулалтаар DZL 7.0 маркийн уурын зуухыг дулаан үйлдвэрлэлд ашиглаж эхэлсэнтэй холбоотой байна.

Уурын зуухны үйлдвэрлэсэн дулааны хэмжээг бүртгэсэн бүртгэл байхгүйн улмаас үйлдвэрлэсэн дулааны хэмжээг зуухны ажилласан цаг, нүүрс, ус, цахилгааны хэрэглээнд үндэслэн тодорхойлжээ.

Цаашид уурын зуухны дулаан үйлдвэрлэлийн хэмжээг тоолуурын заалтанд үндэслэн тогтоох нь эдийн засгийн хувьд үр ашигтай байх боломжтой байна. Дээрх үйлдвэрлэсэн дулаанаар Найрамдал хотхоны 1,119 айл өрх, 64 албан байгууллагын талбайг халааж байгаа бөгөөд үүний 207,600м² буюу 75% нь орон сууцны айл өрх байна.

Дулааны үйлдвэрлэлийг хэвийн явуулахад дараах хүчин зүйлүүд нөлөөлсөн байна. Үүнд:

- Зуны их засварын ажлын графикийг аймгийн Засаг даргын орлогчоор 2017 оны 05 дугаар сарын 01-нд батлуулсан боловч графикт хугацаанд ажлыг хийж гүйцэтгээгүй байна. Тухайлбал: Уг графикт 2017 оны 5 дугаар сарын эхний 7 хоногоос 9 дүгээр сарын сүүлийн 7 хоногт 113 ажил гүйцэтгэхээр батлагдсан боловч уурын зуухны засвар үйлчилгээтэй холбоотой 36 ажил, автогражтай холбоотой 3 ажил, цахилгаан хангамжтай холбоотой 36 ажил, усан хангамж ариутгах татуургатай холбоотой 13 ажил, мэргэшүүлэх сургалттай холбоотой 2 ажил нийт 90 ажлыг графикт заасан хугацаанд хийж гүйцэтгээгүй байна.
- Халаалт, хэрэглээний халуун усны үнэ тариф нь өртгөөс доогуур үнээр тогтоогдсон, нийт хэрэглээний 75%-ийг айл өрх эзэлж байгаагаас үндсэн үйл ажиллагааны орлогоор шаардлагатай засвар үйлчилгээг цаг хугацаанд нь хийх санхүүгийн боломж хязгаарлагдмал байна.
- Дулаан үйлдвэрлэлд 2006 оноос ашиглагдаж эхэлсэн DZL 2.8 маркийн 1, 2, 3 дугаар уурын зууханд 2009 онд, DZL 2.8 маркийн 2 дугаар зуух, DZL 4.2 маркийн 4 дүгээр уурын зууханд 2016 онд тус тус их засварын ажил хийсэн бөгөөд 1 болон 3 дугаар уурын зууханд их засвар хийгдээгүй байна. 1, 2, 3 дугаар уурын зуухны ашиглалтын хугацаа дуусч цаашид ашиглах боломжгүй болсон байна.

Дээрх нөхцөл байдлаас харахад хэрэглэгчдийг хүйтний улиралд найдвартай дулааны эрчим хүчээр хангах байгууллагын үндсэн чиг үүрэг бүрэн хангагдаагүй байна. Дулаан үйлдвэрлэлийг хэвийн явуулахад техник тоног төхөөрөмж, технологийн шинэчлэл хийх, зуны их засварын ажлыг хүйтний улирал эхлэхээс өмнө графикт заасан хугацаанд гүйцэтгэх, санхүүгийн эх үүсвэр, нөөц бололцоогоо оновчтой төлөвлөх шаардлагатай байна.

Хэрэглээний халуун усаар хангах үйл ажиллагаа:

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2016 оны төлөвлөгөөний 19, 2017 оны төлөвлөгөөний 18 дугаар заалтанд хэрэглээний халуун усыг 2016 онд хуваарьт өдрүүдэд, 2017 онд өдөр бүр хэрэглэгчдэд түгээх зорилт тавин ажилласан бөгөөд уурын зуухны жижүүрийн бүртгэлд бүртгэгдсэн хэрэглээний халуун усны бүртгэлийг тулгахад 2016 онд

хэрэглээний халуун усаар хангавал зохих 208 өдрөөс 200 өдөр, 2017 онд 365 өдрөөс 243 өдөр тус тус хэрэглээний халуун усаар хэрэглэгчдийг хангасан байна.

Хэрэглэгчдийг хэрэглээний халуун усаар хангасан байдлыг хүснэгтээр харуулбал:

Он	Хэрэглээний халуун ус өгөх хоног	Хэрэглээний халуун ус өгсөн хоног	Гүйцэтгэл хувиар
2017	365	243	67%
2016	208	200	96%

Хүснэгтээс харахад: Хэрэглээний халуун усаар хангах ажил 2017 онд 67%, 2016 онд 96%-тай байна. 2017 онд хэрэглээний халуун усаар хангах ажил өмнөх оноос 29%-иар буурсан нь өдөр бүр байнгын халуун усаар хангах болсонтой холбоотойгоор уурын зууханд ирэх ачаалал нэмэгдэж, гэмтэл ихээр гарсан нь нөлөөлжээ.

Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдээгүй, уурын зуухнуудын ашиглалтын хугацаа дууссаны улмаас эвдрэл, гэмтэл ихээр гарч хэрэглээний халуун усаар хангах чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж чадаагүй байна.

Бохир ус татан зайлуулах үйл ажиллагаа:

Тус байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй цэвэрлэх байгууламж нь 2008 онд ашиглалтанд орсон бөгөөд бохир усыг дамжуулах 3.7 км шугам, бохир усны худаг, насос станцаар дамжуулан жилд 93,320 м³ бохир татан зайлуулж байна.

Аймгийн МХГ-аас 3 үзүүлэлтээр цэвэрлэсэн бохир усанд шинжилгээ хийж, цэвэрлэсэн бохир усны цэвэрлэгээний үр дүн хангалтгүй байгааг тогтоосон бөгөөд цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшинг сайжруулах, техник технологийн шинэчлэл хийх талаар дүгнэлт гаргасан байна.

Цэвэрлэх байгууламжийн өртөг өндөр тул “Ус-Ду” ОНӨААТҮГ нь техник, технологийн шинэчлэлийг бие даан шийдвэрлэх боломжгүй байна. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 12 дугаар зорилтын 37-д “Аймгийн төв, Шивээговь суманд цэвэрлэх байгууламж байгуулж, саарал усыг эргүүлэн ашиглах нөхцлийг бүрдүүлнэ” гэж заасан бөгөөд уг зорилтын хүрээнд зураг, төсөл боловсруулах ажил хийгдэж байна.

Дээрх чиг үүргүүдийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэвэл: Тус байгууллага нь ойрын болон хэтийн төлөвлөгөө байхгүй, зөвхөн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт зарим ажлуудыг хэсэгчлэн тусгасан, орон нутгийн хэмжээнд баримтлах бодлогын цогц баримт бичиггүй байна.


Түүнчлэн компанийн дүрмийг шинэчлэн боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө батлуулж мөрдөх, хэрэглэгчидтэй гэрээ байгуулан дүгнэж ажиллах, халаалтын талбайг бодитоор тооцох, ашиглалтгүй худгийг шугаманд холбох, нөөц усан сан барих, төмөргүйжүүлэх төхөөрөмжийг шинэчилж, чанар стандартад нийцсэн ундны усаар хэрэглэгчдийг хангах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Иймд үндсэн үйл ажиллагааны чиг үүргийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай бодлогын баримт бичгийг боловсруулж, түүнд нийцүүлэн санхүүгийн эх үүсвэрийг тооцоолж, бодлогын түвшинд шийдвэрлүүлэх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитын явцад “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын үзүүлж байгаа ажил, үйлчилгээ, түүний үр өгөөжтэй байдлын талаар 205 хэрэглэгч, 26 ажилчдаас санал асуулга авсан бөгөөд үр дүн нь дараах байдалтай байна.



ХЭРЭГЛЭГЧЭЭС АВСАН САНАЛ АСУУЛГА

1. Та “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг хэрхэн үнэлдэг вэ? гэсэн асуултанд хэрэглэгчийн 83 буюу 40.5% нь сайн, 98 буюу 47.8% нь дунд, 24 буюу 11.7% нь хангалтгүй гэж хариулсан байна.



2. “Ус-Ду” ОНӨААТҮГ-аас халаалт, хэрэглээний халуун, хүйтэн усаар хангах, бохир ус татан зайлуулах үйлчилгээний гэрээ байгуулдаг уу? гэсэн асуултанд хэрэглэгчдийн 79 буюу 38.5% нь тийм, 67 буюу 32.7% нь үгүй, 59 буюу 28.8% нь мэдэхгүй гэж хариулсан байна.

3. “Ус-Ду” ОНӨААТҮГ-т гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэдэг үү? гэсэн асуултанд хэрэглэгчдийн 93 буюу 45.4% нь тийм, 46 буюу 22.4% нь үгүй, 66 буюу 32.2% нь мэдэхгүй гэж хариулсан байна.



4. “Ус-Ду” ОНӨААТҮГ үйл ажиллагаа иргэд, олон нийтэд ил тод нээлттэй байж чаддаг уу? гэсэн асуултанд хэрэглэгчдийн 61 буюу 29.7% нь тийм, 82 буюу 40.0% нь үгүй, 62 буюу 30.3% нь мэдэхгүй гэж хариулсан байна.

5. “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын ажилчдын мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлдэг вэ? гэсэн асуултанд хэрэглэгчдийн 82 буюу 40.0% нь сайн, 96 буюу 46.8% нь дунд, 27 буюу 13.2% нь хангалтгүй гэж хариулжээ.





6. Таныг хэрэглээний төлбөрийн мэдээллээр үнэн зөв, шуурхай хангаж чадаж байна уу? Хэрэв үгүй гэж хариулсан бол мэдээллийг түргэн шуурхай авах талаар саналаа бичнэ үү? гэсэн асуултанд хэрэгчлэгчдийн 100 буюу 48.8% нь тийм, 53 буюу 25.8% нь үгүй, 52 буюу 25.4% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Үгүй гэж хариулсан 53 хэрэглэгчийн 32 буюу 60.3% нь цахимаар мэдээлэл өгөх буюу утсанд мессежээр мэдээлэл өгөх, НӨАТ-ын баримт өгөх, 21 буюу 39.7% нь сар бүр бичилт хийх, байцаагч нарын харилцааны соёлд анхаарах гэсэн байна.

7. “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, стандартад нийцдэг үү? гэсэн асуултанд хэрэглэгчдийн 80 буюу 39.0% нь тийм, 62 буюу 30.2% нь үгүй, 63 буюу 30.8% нь мэдэхгүй гэж хариулсан байна.



8. “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын үйлчилгээг сайжруулах шаардлагатай гэж үзсэн таны санал? “ гэсэн асуултанд хэрэглэгчдээс 122 санал ирүүлсэн бөгөөд бүлэглэж үзвэл:

- 55 буюу 45.1% нь хэрэглээний халуун ус, дулаанаар тогтмол хангах
- 45 буюу 36.8% нь мэдээллийг ил тод түргэн шуурхай хүргэх, үйлчилгээг сайжруулах
- 9 буюу 7.3% нь дуудлагын үйлчилгээг сайжруулах
- 13 буюу 11.4% нь засварчдын мэргэжлийн ур чадварын сайжруулах, байцаагч, дуудлагын жижүүрүүдийн ёс зүйн харилцааг сайжруулах

Санал асуулгын дүнг нэгтгэн дүгнэж үзвэл:


- Халаалт, хэрэглээний халуун, хүйтэн ус, бохир ус татан зайлуулах чиглэлээр иргэдтэй гэрээ байгуулж ажиллах
- Үйл ажиллагаагаа иргэд, олон нийтэд ил тод нээлттэй, түргэн шуурхай хүргэж ажиллах, дуудлагын үйлчилгээг сайжруулах
- Ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, дамжаанд хамруулах, ёс зүйн харилцаа хандлагыг өөрчлөх
- Хэрэглээний төлбөрийн мэдээллийг цахимаар болон мессежээр мэдээлэх
- НӨАТ-ын баримтыг иргэдэд түргэн шуурхай олгох зэрэг хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээ, арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.2 Бүтэц, орон тоо нь хуулийн хүрээнд зохион байгуулагдаагүй байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь 2016-2017 онд Захиргаа, аж ахуйн хэсэг, дулааны хэсэг, ус хангамж, ариутгах татуургын хэсэг, борлуулалтын хэсэг, хэрэглээний хэсэг гэсэн нийт 5 хэсэгтэй үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг схемээр харуулбал:

НААУ-НИЙ “УС-ДУ” ОНӨААТҮГ-ЫН УДИРДАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Схемээс харахад: Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг үйл ажиллагааны чиглэлээр нь орон тоотойгоо уялдуулаагүй, одоогийн бүтцээр 5 хэсэгтэй боловч, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог нарийвчлан тодорхойлоогүй, бүтэц, зохион байгуулалтын схем ойлгомжгүй, оновчтой бус байна.

Мөн Компанийг үүсгэн байгуулсан баримт бичиг болох Компанийн дүрэмд зааснаар “эрх бүхий этгээд нь удирдах зөвлөл байна” гэж заасан боловч Удирдах зөвлөлийг байгуулаагүй, орон тоо, цалин санг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т “үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох” гэж заасны дагуу эрх бүхий этгээдээр тогтоолгохоор заасан боловч аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс хянаж баталжээ.

2016-2017 оны орон тоо, цалингийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

№	Батлагдсан орон тоо, цалин сан	2017 он			2016 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Цалингийн зардал	364,389.9	341,661.3	22,728.6	338,277.0	344,389.9	(6,112.9)
1	Удирдах	10	10	-	10	10	-
2	Гүйцэтгэх	47	46	1	47	44	3
3	Үйлчлэх	7	6	1	5	5	-
	Нийт	64	62	2	62	59	3
	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж цалингийн дүн	5,693.6	5,510.7		5,456.1	5,837.1	

Хүснэгтээс харахад: 2016-2017 онд 62-59 орон тоотой ажиллаж, дунджаар 1 ажилтны цалинд 5,510.7-5,837.1 мянган төгрөг зарцуулжээ. 2016 онд орон тоо дутуу ажилласан боловч “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын захирлын 2016 оны А/32 тоот тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-д өөрчлөлт оруулж ажилчдад 2016 оны 07 сарын 01-нээс хоолны мөнгийг нэмж олгосонтой холбоотой цалингийн зардал 6,112.9 мянган төгрөгөөр хэтэрсэн байна.

2016-2017 онд уурын зуухны инженер, химич, тоолуурын техникч, лаборант гэсэн орон тоо дутуу ажилласан байна. Эдгээр орон тоонд мэргэжлийн боловсон хүчин шаардлагатай бөгөөд орон нутагт боловсон хүчний нөөц хязгаарлагдмал байна.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.5.Б дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Цаашид бүтэц, зохион байгуулалтын схемийг оновчтой, иргэдэд ойлгомжтой хэлбэрээр үнэн зөв тодорхойлох, хуульд заасны дагуу Удирдах зөвлөлийг байгуулж, цалин сан, орон тоог эрх бүхий этгээд буюу компанийн дүрэмд зааснаар удирдах зөвлөлөөр хянуулах, батлуулж ажиллах нь зүйтэй байна.

Орон тоо, цалингийн зардлыг бодитой төлөвлөж батлуулах, зардлыг хэтрүүлэхгүй байх жилийн дундуур зардал нэмэгдүүлэх шийдвэр гаргахгүй байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.3 Хүний нөөцийн бодлого төлөвлөлт хангалтгүй, мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, ажиллагсдын ажлын гүйцэтгэлийг сайжруулах шаардлагатай байна.


Тус байгууллага үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ 2016 онд 59, 2017 онд 62 орон тоотой ажилласан байна. Аудитаар хүний нөөц, боловсон хүчний өнөөгийн байдалд дараах үзүүлэлтүүдээр судалгаа хийлээ. Үүнд:

1. Орон тоог хүснэгтээр харуулбал:

№	Хэсгийн нэр	2017 он			2016 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Захиргаа	9	9	0	9	9	0
2	Борлуулалт	5	5	0	5	5	0
3	Ус хангамж	14	14	0	14	12	2
4	Дулаан	34	32	2	32	31	1
5	Хэрэглээ	2	2	0	2	2	0
Нийт		64	62	2	62	59	3


Хүснэгтээс харахад: 2016 онд 62, 2017 орон 64 орон тоотой ажиллахаар төлөвлөжээ. Энэ нь 2016 онд аймгийн СТСХ-ээр хянуулсан орон тооноос 2-оор илүү төлөвлөсөн байна. Хянагдаж батлагдсан орон тоог үндэслэлгүй нэмэгдүүлж төлөвлөсөн бөгөөд 2016 онд тоолуурын техникч, химич, лаборант, зуухны инженер, 2017 онд зуухны инженер, нүүрсний сахиул гэсэн орон тоонд хүн ажиллуулаагүй байна. Энэ нь мэргэжлийн боловсон хүчин байхгүйтэй холбоотой байна.

2. Ажиллагсдын боловсролын түвшинг графикаар харуулбал:



Графикаас харахад: Нийт ажилчдын 50% нь тусгай дунд, 31% нь дээд, 17% нь бүрэн дунд, 2% нь бүрэн бус дунд боловсролтой байна.


3. Ажиллагсдын мэргэжлийг графикаар харуулбал:



Графикаас харахад: Нийт ажилчдын 13%-ийг инженер техникийн ажилтан эзэлж байгаа нь мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд хуулиар хүлээн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, чанартай ажил үйлчилгээ үзүүлэхийн тулд мэргэжлийн, чадварлаг боловсон хүчнээр хангагдах, орон тоо, цалингийн сангаа нэмэгдүүлэх асуудлыг эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

4. Ажиллагсдыг тухайн байгууллагад ажилласан жилээр нь авч үзвэл:



Хүснэгтээс харахад нийт ажилчдын 67% нь 1-3 жил, 21% нь 4-8 жил, 12% нь 9-15 жил ажилласан байна. Гагнуурчин, сантехник, уурын зуух, орон сууцны засварчин гэсэн ажлын байранд ажиллагсад хамгийн тогтвор суурьшилгүй ажилласан байна. Энэ нь тухайн ажлын байрны нөхцөл хүнд, цалин хөлс, нийгмийн баталгаа нь хангалтгүй байгаатай холбоотой байна.

Цаашид ажиллагсдыг тогтвор сууршилтай ажиллуулах нөхцлийг хангах, цалин хөлс болон нийгмийг асуудлыг зохистой хэмжээнд шийдвэрлэж ажиллах шаардлагатай байна.

Тус байгууллагын хүний нөөц, боловсон хүчний баримт материалын иж бүрдлийг шалгахад: нээвэл зохих 62 хувийн хэргээс 36 ажилтанд хувийн хэрэг нээсэн бөгөөд үүний 55.5% буюу 20 ажилтны хувийн хэрэг шаардлага хангахгүй байна. Тухайлбал: хувийн хэргийн баяжилт хийгдээгүй, улирлын чанартай ажилладаг уурын зуухны зарим галч нарт хувийн хэрэг нээгээгүй, бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсон боловч ажлын байрны тодорхойлолтыг шинэчлээгүй байна. Түүнчлэн боловсон хүчний дэлгэрэнгүй судалгаа байхгүй, тухай бүр өөрчлөлт шинэчлэлт хийдэггүй, хүний нөөц хариуцсан орон тооны ажилтантай боловч тухайн ажилтны ажлын гүйцэтгэл хангалтгүй, ажлын байрны тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Загвар, зааврыг батлах тухай” тогтоол, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар заалтыг мөрдөж ажиллах, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, үндсэн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай боловсон хүчин бэлтгэх, ажиллагсдын ажлын гүйцэтгэлийг сайжруулах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар байгууллагын үйл ажиллагааны талаар 26 ажилчнаас санал асуулга авсан бөгөөд үр дүн дараах байдалтай байна.

Ажилчдаас авсан санал асуулгын дүн

1. **“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна уу?** гэсэн асуултанд нийт ажилчдын 26 буюу 100% тийм гэж хариулсан байна.
2. **Удирдах ажилтны зан харилцааг хэрхэн үнэлдэг вэ?** гэсэн асуултанд санал асуулгад оролцсон нийт ажилчдын 26 буюу 100% сайн гэж хариулжээ.
3. **Ажилчдын зүгээс гаргасан санал хүсэлтийг удирдлага хүлээн авч хэрхэн шийдвэрлэдэг вэ?** гэсэн асуултанд санал асуулгад оролцсон нийт ажилчдын 22 буюу 84.6% нь сайн, 4 буюу 15.4% нь дунд гэж хариулсан байна.
4. **Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөр хамгааллын ажиллагаа хэрхэн хангагддаг вэ?** гэсэн асуултанд санал асуулгад оролцсон нийт

ажилчдын 13 буюу 50% нь сайн, 9 буюу 39.1% нь дунд, 4 буюу 10.9% нь муу гэж хариулсан байна.

5. **Ажиллагсдын цалин хөлс, нийгмийн асуудлын талаарх таны сэтгэл ханамж** гэсэн асуултанд санал асуулгад оролцсон нийт ажилчдын 3 буюу 11% нь сайн, 21 буюу 81% нь дунд, 2 буюу 8% нь муу гэж хариулсан байна.
6. **Байгууллагын үйл ажиллагаа болон санхүүгийн талаарх мэдээллийг ил тод нээлттэй мэдээлдэг үү?** гэсэн асуултанд санал асуулгад оролцсон нийт ажилчдын 12 буюу 46.1% нь сайн, 13 буюу 50% нь дунд, 1 буюу 3.9% нь муу гэж хариулжээ.
7. **Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой таны санал** гэсэн асуултанд дараах байдлаар хариулжээ:

Ажилчдын цалин хөлс, нийгмийн баталгааг хангах, байгууллагын борлуулалтын үнийг хянаж шийдвэрлэх, ажилчдыг идэвхижүүлэх урамшуулах шаардлагатай байна гэж хариулжээ.

Санал асуулгын дүнгээс үзэхэд: Байгууллагын ажиллагсдыг тогтвор сууршилтай ажиллуулах, ажилчдын цалин хөлс, нийгмийн баталгааг хангах, үйл ажиллагаа болон санхүүгийн талаар мэдээлэл хийх, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөр хамгааллыг сайржуулах тал дээр анхаарч ажиллах шаардлагатайг байгааг харуулж байна.

1.4 Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанаас 2016-2017 онд нийт 146,701.0 мянган төгрөгийн ашигтай ажиллажээ.

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь 2016 онд 130,183.0 мянга, 2017 онд 50,918.0 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллагааар төлөвлөж, 2016 онд 166,355.1 мянган төгрөгийн ашигтай, 2017 онд 412,389.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2017 онд орлогыг нэмэгдүүлэх, зардал бууруулах, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

1. Үйлдвэрлэн түгээж буй хэрэглээний халуун усны тарифт өөрчлөлт оруулахаар тооцоо судалгаа хийж, аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлд хүргүүлсэн байна. Мөн цэвэр усны үнэ тарифыг хүн амд 600-750, үйлдвэр аж ахуйн нэгжид 1400-2000, бохир усны үнэ тарифыг хүн амд 400-550, үйлдвэр аж ахуйн нэгжид 1250-1800 төгрөг болгон шинэчлэн батлуулсан байна. Үүнтэй холбоотойгоор орлогыг 56,267.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.
2. Үндсэн үйл ажиллагаанаас хүлээж буй алдагдлыг нөхөх зорилгоор тусгай зөвшөөрлийн хүрээнд “Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын техникийн давхрын шугам сүлжээний их засварын ажил”, “Нийтийн эзэмшлийн орон сууцны 1-р байрны подвалийн шугам шинэчлэх ажил” зэрэг аймагт зарлагдаж буй хөрөнгө оруулалтын ажлын тендерт оролцон гүйцэтгэгчээр шалгарч, 2016 онд 420,072.0 мянган төгрөгийн 5 ажил, 2017 онд 291,179.9 мянган төгрөгийн 3 ажил тус тус хийж, нийт 711,251.9 мянган төгрөгийн орлого, 564,550.9 мянган төгрөгийн зардал гаргаж 146,701.0 мянган төгрөгийн ашигтай ажиллажээ.
3. Нүүрсний зардлыг бууруулах зорилгоор зуухны үлээлгийн системд нэмэлт тохируулга хийж, 2016 онд 266,011.2 мянган төгрөгийн нүүрс зарцуулж байсан бол 2017 онд 220,386.8 мянган төгрөг болж нүүрсний зардлыг өмнөх оноос 45,624.4 мянган төгрөг буюу 17%-иар бууруулсан байна.

4. Цахилгааны зардлыг бууруулахтай холбоотой зуухны нэмэлт усны насос, цэвэр усны 2-р өргөлтийн насос, станцын сүлжээний насос цахилгаан бууруулагч тавьсанаар 3390 квт буюу 435.6 мянган төгрөгийн цахилгаан эрчим хүч хэмнэсэн байна.

Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2017 онд байгууллагын алдагдлыг 147,411.8 мянган төгрөг буюу 35.7 %-иар бууруулжээ.

Үйл ажиллагааны орлого, зарлагыг бодитой төлөвлөж байна уу?

Бүлэг 2

Үйл ажиллагааны орлого, зардлыг бодитой төлөвлөөгүй, үнэн зөв бүртгэж тайлагнаагүй, мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул, үнэ тарифыг зохистой хэмжээнд шинэчлэн батлуулах шаардлагатай байна.

2.1 Байгууллага үндсэн үйл ажиллагааны орлого, зардлыг тендер шалгаруулалтын орлогоос хамааруулан нэмэгдүүлж төлөвлөсөн нь бодит байдалтай нийцэхгүй байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан үйлдвэрлэлийн болон санхүүгийн төлөвлөгөөг батлуулан мөрдөж ажиллах үүрэгтэй боловч 2016 онд тус байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн төлөвлөгөөг батлаагүй, захиралтай гэрээ байгуулаагүй байна. Иймд байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтнуудын гарган ирүүлсэн 2016 оны төлөвлөгөөг аудитад ашиглалаа.

Орлогын төлөвлөлтийн талаар:

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ны үйл ажиллагааны орлого нь дараах орлогоос бүрдэж байна. Үүнд:

Үндсэн үйл ажиллагааны орлого

- Дулаан
- Хэрэглээний халуун ус болон цэвэр ус олборлож, түгээх
- Бохир ус татан зайлуулах

Үйл ажиллагааны бус орлого нь:

- Тендерийн орлого
- Тоолуур баталгаажуулалтын орлого
- Засвар үйлчилгээний орлого
- Туслах аж ахуй

2016-2017 оны орлогын төлөвлөгөөг нэр, төрлөөр нь хүснэгтээр харуулбал:

№	Орлогын нэр төрөл	2017 он		2016 он	
		Төлөвлөсөн	Хувь	Төлөвлөсөн	Хувь
1	Халаалт	778,263.3	43.5%	800,116.6	62.1%

/мянган төгрөгөөр/

2	Цэвэр ус	133,186.1	7.4%	133,417.9	10.3%
3	Бохир ус	87,237.6	4.9%	57,004.0	4.4%
4	Хэрэглээ	25,362.7	2.0%	26,995.8	2.1%
5	Тоолуурын орлого	30,832.0	1.7%		0.0%
6	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	300,000.0	16.8%	271,770.0	21.1%
7	Зуухны их засвар	300,000.0	16.8%		0.0%
8	Подвалын ажил	120,000.0	6.7%		0.0%
9	Туслах аж ахуйн орлого	2,000.0	0.1%		0.0%
10	Засвар үйлчилгээний орлого	10,000.0	0.6%		0.0%
11	Бусад орлого	1,000.0	0.1%		0.0%
Нийт		1,789,881.9	100%	1,289,304.4	100%

Хүснэгтээс харахад: 2016-2017 онд нийт орлогын 43%-62% нь дулаан, 7%-10% нь цэвэр ус, 4%-5% бохир ус, 2% нь хэрэглээний халуун ус, 0-2% нь тоолуур баталгаажуулалтын орлого, 21%-41% нь хөрөнгө оруулалтын ажил, 0.1%-ийг бусад орлого тус тус эзэлж байна.

2017 онд төлөвлөсөн нийт орлогын 59.5%-ийг үндсэн үйл ажиллагааны орлого эзэлж байна. Энэ нь бүтээгдэхүүн үйлчилгээний тоо хэмжээнд өөрчлөлт ороогүй, үнэ тариф тогтмол байсан тул нийт орлогоо 100% үндсэн үйл ажиллагааны орлогоор бүрдүүлэхээр төлөвлөх боломжгүй, 40.5%-ийг туслах үйл ажиллагааны орлого олж бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 27.9%-иар нэмэгдүүлсэн нь хөрөнгө оруулалтын ажлын орлогыг төлөвлөсөнтэй холбоотой байна. Хөрөнгө оруулалтын ажил нь тендер сонгон шалгаруулалтын үр дүнгээр гүйцэтгэгчийг шалгаруулдаг тул тухайн хөрөнгө оруулалтын ажилд гүйцэтгэгчээр шалгарах эсэх нь тодорхойгүй нөхцөлд орлого төлөвлөх нь бодит байдалтай нийцэхгүй байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Халаалтын орлогыг бууруулж төлөвлөсөн нь аймгийн Засаг даргын захирамжаар халаалтын улиралд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор 2017 онд дулааны орлогыг 2.8%-иар бууруулж төлөвлөсөн байна.

Зардлын төлөвлөлтийн талаар:

Тус байгууллага нь 2016 онд 1,159,121.4 мянган төгрөгийн зардал төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 1,599,876.6 мянган төгрөг, 2017 онд 1,738,963.9 мянган төгрөгийн зардал төлөвлөж, гүйцэтгэлээр 1,852,544.4 мянган төгрөгийн зардлыг бүртгэж, тайлагнасан байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2016, 2017 оны зардлын төлөвлөлтийг нэр, төрлөөр нь хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

Зардлын зүйл	2017	Эзлэх хувь	2016	Эзлэх хувь
Цалин ндш	413,619.9	23.8%	382,624.60	33.0%
Нүүрс	296,674.8	17.1%	240,097.7	20.7%
Шатахуун	43,377.1	2.5%	40,500.0	3.5%
Сэлбэг материал, урсгал засвар	73,452.7	4.2%	71,815.8	6.2%
Элэгдэл	223,174.0	12.8%	211,113.0	18.2%
Цахилгаан	147,392.0	8.5%	118,349.5	10.2%

Тээврийн зардал	18,700.0	1.1%	13,000.0	1.1%
Хөрөнгө оруулалтын зардал	420,000.0	24.2%	-	
Буцалтгүй тусламж	5,400.0	0.3%	4,000.0	0.3%
Хөдөлмөр хамгаалал	10,540.0	0.6%	5,500.0	0.5%
Харуул хамгаалалтын зардал	12,204.0	0.7%	10,320.0	0.9%
Тоолуур баталгаажилт	20,000.0	1.2%	-	
Халаалт	12,000.0	0.7%	18,247.02	1.6%
Бусад борлуулалт, удирдлага	42,429.3	2.4%	43,553.8	3.8%
Нийт дүн	1,738,963.9	100%	1,159,121.41	100%

Хүснэгтээс харахад: 2017 онд зардлын төлөвлөгөөг өмнөх оноос 579,842.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Үүнд дараах зардлуудыг нэмэгдүүлэн төлөвлөсөн холбоотой байна.

Нэмэгдүүлэн төлөвлөсөн нийт зардлын 72.4% буюу 420,000.0 мянган төгрөг нь хөрөнгө оруулалтын ажлын зардал, 9.7% буюу 56,577.0 мянган төгрөг нь нүүрсний зардал, 5.3% буюу 30,995.3 мянган төгрөг нь цалин, ндш-ийн зардал, 5% буюу 29,042.5 мянган төгрөг цахилгааны зардал, 3.4% буюу 20,000.0 мянган төгрөг нь тоолуурын баталгаажилтын зардал, 4% буюу 23,227.7 мянган төгрөг нь усны шинжилгээ, зохицуулалт үйлчилгээний хөлс, сургалт, хөдөлмөр хамгаалал, бичиг хэрэг, элэгдлийн зардлууд эзэлж байна.

Зардлыг нэмэгдүүлэн төлөвлөсөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын зардлыг 420,000.0 мянган төгрөгөөр баталсан нь тендер шалгаруулалтад оролцон гүйцэтгэгчээр шалгарсан тохиолдолд гарах зардал бөгөөд тендерт шалгарах эсэх нь тодорхойгүй нөхцөл байдалд зардал төлөвлөх нь бодит байдалтай нийцэхгүй байна.
2. 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хэрэглээний халуун усаар хэрэглэгчдийг өдөр бүр хангах болсонтой холбогдон нүүрсний болон цахилгааны зардлыг нэмэгдүүлэн төлөвлөжээ.
3. Орон тоог 2-оор нэмж баталсан, мөн 2016 он 07 дугаар сараас эхлэн ажилчдад хоолны хөнгөлөлт олгох болсонтой холбогдуулан цалингийн зардлыг 30,995.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.
4. Байгууллагын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд айл өрх, албан байгууллагын тоолуурыг 100% баталгаажуулах зорилт дэвшүүлсэнтэй холбогдуулан тоолуур баталгаажилтын зардлыг төлөвлөсөн байна.

Цаашид байгууллагын үйлдвэрлэлийн болон санхүүгийн төлөвлөгөөг батлуулж мөрдөж ажиллах, хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөгөөнд батлахгүй байх, орон тоо зардлыг үндэслэлгүй нэмэгдүүлэн төлөвлөхгүй байх шаардлагатай байна.

2.2 Орлогын төлөвлөгөөг 2017 онд 19.5%-иар дутуу биелүүлсэн, НББ-ийн тухай хуульд заасны дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй байна.

Тус байгууллага нь 2016 онд 1,289,304.4 мянган төгрөгийн орлого төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 1,766,231.7 мянган төгрөг, 2017 онд 1,789,881.9 мянган төгрөгийн орлого

төлөвлөж, гүйцэтгэлээр 1,440,155.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж тайлагнасан байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь 2016-2017 онд үйл ажиллагааны орлогыг дараах байдлаар бүрдүүлсэн байна.

/мянган төгрөгөөр/

№	Орлогын нэр төрөл	2017 он		Зөрүү	Хувь	2016 он		Зөрүү	Хувь
		Төлөвлөсөн	Гүйцэтгэл			Төлөвлөсөн	Гүйцэтгэл		
1	Халаалт	778,263.3	778,856.7	-593.4	-0.1%	800,116.6	757,863.7	42,252.9	5.3%
2	Цэвэр ус	135,186.3	140,186.1	-4,999.8	-3.7%	133,417.9	125,697.7	7,720.2	5.8%
3	Бохир ус	87,237.6	88,930.8	-1,693.2	-1.9%	57,004.0	53,725.0	3,279.0	5.8%
4	Хэрэглээ	25,362.7	21,827.0	3,535.7	13.9%	26,995.8	19,291.4	7,704.4	28.5%
5	Тоолуурын орлого	30,832.0	31,035.5	-203.5	-0.7%	0.0	695.5	-695.5	
6	Хөрөнгө оруулалтын ажил	720,000.0	364,199.9	355,800.1	49.4%	271,770.0	795,626.5	-523,856.5	-192.8%
7	Туслах аж ахуйн орлого	2,000.0	5,265.0	-3,265.0	-163.3%		3,834.2	-3,834.2	
8	Засвар үйлчилгээний орлого	10,000.0	9,707.4	292.6	2.9%		9,473.4	-9,473.4	
9	Бусад орлого	1,000.0	146.3	853.7	85.4%		24.1	-24.1	
Нийт		1,789,881.9	1,440,154.7	349,727.2	19.5%	1,289,304.4	1,766,231.5	-476,927.2	-37.0%

Хүснэгтээс харахад: Орлогын төлөвлөгөөг 2016 онд 37.0%-иар давуулан биелүүлсэн бол 2017 онд 19.5%-иар дутуу биелүүлсэн байна. Энэ нь тайлант онуудад тендер шалгаруулалтад оролцож хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэсэнтэй холбоотой орлого өсч, буурсан байна.

Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2017 оны 30 дугаар тогтоолоор цэвэр, бохир усны үнэ тарифыг нэмсэнтэй холбоотойгоор бохир ус татан зайлуулах үйлчилгээний орлогыг 53.0%-иар нэмэгдүүлэн төлөвлөжээ.

Аудитаар тус байгууллагын орлогын бүртгэл, тайлагналыг анхан шатны баримттай тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 2016 онд 107 айл, өрхийн 446.7 мянган төгрөгийн илүү төлөлтийг урьдчилж орсон орлогоор тайлагнаагүй авлага-орлого дансанд бичсэн бөгөөд уг бичилтээр 23 айлын 415.3 мянган төгрөгийн авлагыг хааж, бүртгэлийн алдаатай бичилт хийсэн байна.
- 2017 онд тоолуур баталгаажилтын орлогын 311 ширхэг 11,042.1 мянган төгрөгийн бэлэн мөнгөний орлогын баримтыг кассын баримтанд үдэж архивлаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй байна.
- 2016 онд тоолуур баталгаажилтын орлого 84.0 мянган төгрөгийг бэлнээр хураасан боловч кассанд тушаагаагүй. Данс бүртгэлд авлага үүсгэж бүртгээгүй байна.
- Айл өрх хариуцсан борлуулалтын байцаагч нарын өрхийн бичилтийн дэвтэрт холбогдох албан тушаалтан хяналт тавиагүй, дэвтрийн бичилтээр тулган баталгаажуулж, хяналгүйгээр борлуулалтын програмд ажил үйлчилгээг шивж баталгаажуулсан байна.

- 2016 онд 4,397.9 мянга, 2017 онд 363,252.1 мянган төгрөгийг байгууллагад төлөх өр төлбөр-орлого гэсэн бүртгэлийн алдаатай бичилт хийж, тайлагнасан байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.4.2, 14.4.3, 14.4.5-д заасныг тус тус зөрчжээ.

Аудитаар орлогын бүртгэл тайлагналтай холбоотой 379,638.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 84.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Цаашид бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, борлуулалтын дэвтрийг сар бүр хянаж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.3 Дараа тайлангаар бэлнээр олгож буй мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул, бэлэн мөнгөний зарцуулалтад хяналт тавих эрх бүхий этгээдүүд хөрөнгө бэлтгэсэн байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь 2016 онд 1,159,121.4 мянган төгрөгийн зардал төлөвлөж гүйцэтгэлээр 1,599,876.6 мянга, 2017 онд 1,738,963.9 мянган төгрөгийн зардал төлөвлөж гүйцэтгэлээр 1,852,544.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2016, 2017 оны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/ Зөрүү
2017	1,738,963.9	1,852,544.4	(113,580.5)
2016	1,159,121.4	1,599,876.6	(440,755.2)

Хүснэгтээс харахад: Зардлын төлөвлөлт өмнөх оноос 50%-иар өссөн шалтгаан нь хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэхтэй холбоотой гарах зардлыг нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна. Гүйцэтгэл өмнөх оноос 15.7%-иар өссөн нь төлөвлөгдөөгүй зардал буюу үндсэн хөрөнгө данснаас хассаны гарзыг хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна. Жил бүр зардлын төлөвлөгөөг хэтрүүлсэн байна. /Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хавсралт №1-д харуулав./

Тухайлбал: 2016 онд 20 нэр төрлийн, 2017 онд 7 нэр төрлийн зардлыг төлөвлөгөөнөөс 6.5-38%-иар буюу нийт 554,335.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Зардлын хэтрэлтэд дараах зардлууд голлох нөлөө үзүүлжээ. Үүнд:

- 2016 онд орон нутгаас зарласан хөрөнгө оруулалтын ажилд гүйцэтгэгчээр оролцон 5 ажил гүйцэтгэсэн бөгөөд уг ажлыг гүйцэтгэхэд 318,455.8 мянган төгрөг зарцуулжээ.
- 2017 онд 663,876.5 мянган төгрөгийн балансын үнэ бүхий 327,872.5 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хассантай холбоотойгоор үндсэн хөрөнгө данснаас хассаны гарзыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.
- 2016-2017 онд элэгдлийн зардал 5%-19% буюу 10,765-42,583.4 мянган төгрөгөөр хэтэрсэн байна. Энэ нь 2016 онд 507,767.9 мянга, 2017 онд 147,402.3 мянган

төгрөгийн үндсэн хөрөнгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон өөрийн хөрөнгөөр бэлтгэн дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

- 2016-2017 онд сэлбэг хэрэгслийн зардал төлөвлөснөөс 31%-74% буюу 22,877.2-53,054.1 мянган төгрөгөөр хэтэрчээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар уурын зуухны шинэчлэлт хийгдэнэ гэж төлөвлөгдсөн боловч халаалтын улирал эхлэхээс өмнө хийгдээгүй тул хуучин уурын зууханд урсгал засвар хийсэнтэй холбоотойгоор сэлбэг хэрэгслийн зардал хэтэрчээ.
- 2016-2017 онд тээврийн зардал төлөвлөснөөс 34%-54%-иар буюу 6,967.1-7,248.9 мянган төгрөгөөр хэтэрсэн байна. Энэ нь 2016 онд нүүрс тээврийг ажил гүйцэтгүүлэх гэрээгээр хувь хүнээр гүйцэтгүүлсэн, 2017 онд төмөр замаар дамжуулан тээвэрлэсэн бөгөөд төмөр замын тариф нэмэгдсэн зэргээс шалтгаалан тээврийн зардал хэтэрсэн байна.

Жил бүр зардлыг байгууллагын санхүүгийн төлөвлөгөөний дагуу зарцуулаагүй, тодорхой бус нөхцөл шалтгааны улмаас төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулжээ.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2016, 2017 оны зардлын бүтцийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

Зардлын зүйл	2016	Эзлэх хувь	2017	Эзлэх хувь
Цалин ндш	390,054.4	24%	385,783.21	21%
Нүүрс	266,011.2	17%	220,386.80	12%
Шатахуун	40,921.8	3%	41,217.80	2%
Сэлбэг материал, урсгал засвар	124,869.9	8%	96,330.00	5%
Элэгдэл	221,878.0	14%	265,757.40	14%
Цахилгаан	136,105.1	9%	148,887.50	8%
Тээврийн зардал	19,967.1	1%	25,948.90	1%
Хөрөнгө оруулалтын зардал	318,455.8	20%	246,095.10	13%
Буцалтгүй тусламж	16,650.5	1%	3,820.00	0%
Хөдөлмөр хамгаалал	9,195.0	1%	10,535.20	1%
Харуул хамгаалалтын зардал	9,839.0	1%	12,204.00	1%
Тоолуур баталгаажилт	0	0%	17,741.90	1%
Бусад БУЗ	45,928.8	3%	49,964.30	3%
ҮХДХГарз	0	0%	327,872.50	18%
Нийт	1,599,876.6	100%	1,852,544.61	100%

Зардлын бүтцээс харахад: Нийт зардлын 21%-24% нь цалин НДШ, 12%-17% нь нүүс, 2%-3% нь шатахуун, 5%-8% нь сэлбэг материал, урсгал засвар, 14% нь элэгдэл, 8%-9% нь цахилгаан, 1% нь тээвэр, 1% нь хөдөлмөр хамгаалал, 2%-3%, 3% нь бусад борлуулалт удирдлагын зардал, 18% нь үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз байна.

Аудитаар тус байгууллагын зардлын журналыг анхан шатны баримтай тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 2016 онд 3,050.0 мянга, 2017 онд 486.3 мянга, нийт 3,536.3 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан байна.
- Захирлаар батлуулаагүй захиалгын хуудсаар 2016 онд нийт 115,755.5 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

- 27 нэр төрлийн 928,591.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтанд орсон хугацааг зөрүүтэй тогтоосноос элэгдлийн зардлыг 17,145,5 мянган төгрөгөөр илүү, 30,690.2 мянган төгрөгөөр дутуу, нийт 13,544.7 мянган төгрөгийн зөрүүтэй тооцсон байна.
- Тус байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хамааралгүй 220,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий “Эко сүмбэр” хотхоны шинэ хорооллын шугамыг аймгийн Орон нутгийн өмчийн албаны 2012 оны 77 дугаартай албан тоотоор данс бүртгэлд тусгаж, үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгөнд 31,428.6 мянган төгрөгийн элэгдлийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Эдгээр нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.4, 20.2.5 дахь заалтуудыг тус тус зөрчжээ.

Иймд анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан 3,536.3 мянган төгрөгийн 536.3 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 3,000.0 мянган төгрөгийн зөрчилд ерөнхий нягтлан бодогч У.Батдолгорт хариуцлага тооцуулах албан шаардлага өгч, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой 147,184.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь арилжааны 4 банкинд данстай боловч 2016 онд 533,620.6 мянга, 2017 онд 470,394.9 мянга, нийт 1,004,015.5 мянган төгрөгийг кассаас бэлнээр зарцуулжээ. Нийт бэлнээр зарцуулсан мөнгөн хөрөнгийн 556,180.0 мянган төгрөг буюу 55.4% нь дараа тайлангаарх худалдан авалт байна. Энэ нь мөнгөн хөрөнгийг хяналтгүй, үр ашиггүй зүйлд зарцуулах эрсдлийг бий болгож байгаа төдийгүй эмх замбараагүй байдлыг бий болгож байна.

Иймд дараа тайлангийн журмыг шинэчлэн боловсруулах, бэлэн мөнгөний зарцуулалтад хяналт тавих эрх бүхий этгээдүүд дараа тайлангаар материал бэлтгэхгүй байх, мэдээлэл технологийн шинэчлэл, цахим сүлжээг ашиглан худалдан авалтыг дансаар хийж гүйцэтгэх, уламжлалт арга барилаас салах, мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байгаа тул зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.4 Үнэ тарифыг үйлдвэрлэлийн өртөгтэй уялдуулж зохистой хэмжээнд шинэчлэх шаардлагатай байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь Эрчим хүчний тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий этгээдээс тогтоосон дараах үнэ тарифыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллажээ. Үүнд:

- Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2014 оны “Үнэ хянаж батлах тухай” 09 дүгээр тогтоолоор дулааны үнийг айл өрхөд 1м^2 400 төгрөг, аж ахуйн нэгж байгууллагад 1м^3 950 төгрөг, төсвийн байгууллагад 1м^3 1400 төгрөгөөр тус тус тогтоожээ.

- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2014 оны 59 дугаар тогтоолоор усны үйлчилгээний суурь хураамжийг айл өрхөд 1800, Үйлдвэр аж ахуйн нэгжийг шугамын голчоос хамааруулан 3600-384000 төгрөг, цэвэр усыг хүн амд 0.6 төг/л- 4500 төг хүн/сар, бохир усыг хүн амд 0.4 төг/л, үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллагад 1.25 төг/л-ээр тус тус тогтоожээ.
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2017 оны 30 дугаар тогтоолоор цэвэр усыг хүн амд 0.75төг/л, бохир ус 0.55 төг/л, Үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагад цэвэр усыг 2.0 төг/л, бохир усыг 1.8 төг/л-ээр тус тус шинэчлэн тогтоожээ.
- Аймгийн Засаг даргын 2011 оны А/05 дугаар захирамжаар хэрэглээний халуун усыг айл өрхөд 1м³ 690 төгрөг, төсөвт байгууллагад 1м³ 1040 төгрөгөөр тус тус баталжээ.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2016, 2017 онд мөрдөж ажилласан бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, тарифыг хүснэгтээр харуулбал:

/төгрөгөөр/

Д/д	Бүтээгдэхүүний үйлчилгээний төрөл	Хэрэглэгчийн төрөл	Үнэ тариф
1	Халаалт	Айл өрх	400
2		Төсвийн байгууллага	1,400
3		Аж ахуйн нэгж	950
4	Хэрэглээний халуун ус	Айл өрх	690
5		Албан байгууллага	1,040
6	Цэвэр ус	Айл өрх	750
7		Албан байгууллага	2,000
8	Бохир ус	Айл өрх	550
9		Албан байгууллага	1,800

Дээрх хүснэгтээс харахад: Хэрэглээний халуун усанд өртөг шингээн түгээж байгаа боловч цэвэр усны үнэ тарифаас бага үнэтэй байна. Халаалтын үнийг тогтоохдоо хувийн хэвшлийг дэмжих зорилгоор төсвийн байгууллага, аж ахуйн нэгжийн тарифыг зөрүүтэй тогтоосон нь үндэслэлгүй бөгөөд тус байгууллагын алдагдалд нөлөөлж байна. Иймд үнэ тарифыг айл өрх, албан байгууллагаар гэсэн нэг ижил ангиллаар тогтоох шаардлагатай байна.


Хэрэглэгчдэд хүргэж буй 1м³ буюу 1 тонн хэрэглээний халуун усны бодит өртөг 2017 оны байдлаар 3,062 төгрөг байхад тогтоосон тариф нь 690 төгрөг буюу өртгөөс 2,362 төгрөгөөр буюу 4 дахин бага үнэтэй байна. Хэрэглээний халуун ус үйлдвэрлэлээс 2016 онд 76,601.8 мянга, 2017 онд 73,643.3 мянган төгрөгийн алдагдал хүлээжээ. Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3-т зааснаар тариф батлах эрх бүхий этгээд нь Эрчим хүчний зохицуулах зөвлөл боловч аймгийн Засаг даргын 2011 оны Б/05 дугаар захирамжаар хэрэглээний халуун усны үнэ тарифыг тогтоосон нь хууль эрхзүйн актыг зөрчсөн байна. Үүнээс харахад хэрэглээний халуун усны үнэ тарифыг зайлшгүй шинэчлэн батлах шаардлага тулгарч байна.

Айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний үнэ тариф төсөвт байгууллагаас 3.5 дахин хямд байна. “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын дулаан хэрэглэгчдийн 75% нь айл, өрх боловч борлуулалтын орлогын 17.7%-ийг эзэлж байна. Дулааны үнэ тарифыг 2014 онд

шинэчлэн тогтоосон боловч 2012-2013 оны тооцоо судалгаанд үндэслэжээ. Байгууллагын санхүүгийн төлөвлөгөөнөөс харахад дулаан үйлдвэрлэлээс 2017 онд 69,867.0 мянган төгрөгийн алдагдал хүлээхээр батлагджээ.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2017 оны 30 дугаар тогтоолоор цэвэр, бохир усны үнэ тарифыг шинэчлэн тогтоожээ.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаатай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг зарим аймгуудын дулааны байгууллагын мөрдөж буй хэрэглээний халуун усны үнэ тарифыг харьцуулж үзвэл:



Хүснэгтээс харахад: Манай аймгийн хэрэглээний халуун усны үнэ, тариф бусад аймгуудаас 2.7-3.6 дахин бага үнэтэй байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь өртгийг хэсэг тус бүрт хуримтлуулан бүртгэж байна. Захирлын 2017 оны А/04 тоот тушаалаар байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх НБББББ-ийг баталжээ.

Аудитаар борлуулалтын өртөгт бүртгэсэн гүйлгээнд дүн шинжилгээ хийхэд дараах зөрчил илэрлээ.

- НБББББ-ийн бүртгэл хэсэг дэх бүтээгдэхүүний өртгийн бүртгэл нь үйлдвэрлэн, олборлон, дамжуулан түгээж буй бүтээгдэхүүн үйл ажиллагааны онцлогтой нийцэхгүй байна. Үйлдвэрлэсэн дулаан, хэрэглээний халуун усыг агуулахад хадгалах боломжгүй юм.
- НБББББ-ийн 6402-0100 данс- Гадагш худалдсан барааны өртөг, ҮНЗ-Их засварын зардал-Дулаан хонхор, ҮНЗ-Их завсарын зардал-Цэвэр ус, 7017-0000-данс-Тендэртэй холбоотой зардал, 7101-0000-данс-Байгууллага хөгжүүлэлтийн зардлын нийт 250,148.7 мянган төгрөгийг борлуулалт болон удирдлагын зардалд бүртгэж тайлагнахаар заасан боловч борлуулалтын өртөгт хуваарилсан байна.

Эдгээр нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 18.2-т заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд бүтээгдэхүүний өртөгт шингээж буй зардлыг үнэн зөв тооцож бүртгэх, НБББББ-ийг хянаж, алдаатай заалтуудыг залруулах, хэрэглээний халуун ус, дулааны үнэ

тарифыг хэрэглэгчдийн орлого, үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг харгалзан зохистой хэмжээнд тогтоох талаар холбогдох байгууллагуудад зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.5 Өглөг, авлагыг үнэн зөв бүртгэж тайлагнаагүй байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд 2017 оны жилийн эцсийн байдлаар 103,396.3 мянган төгрөгийн авлага, 137,647.5 мянган төгрөгийн өр, төлбөр бүртгэлтэй байна.

Оны эхэнд 79,520.8 мянган төгрөгийн авлага бүртгэгдсэн бөгөөд авлага нэмэгдсэн шалтгаан нь НӨАТ, ААНОАТ-ын авлага 32,090.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, албан газрын авлага 14,128.8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Өр төлбөр өмнөх оноос 66,998.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь урьдчилж орсон орлогоор бүртгэсэн хөрөнгийн орлого 113,000.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, байгууллагад төлөх өр төлбөр 44,484.3 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

2017 оны жилийн эцсийн тайланд тусгагдсан өглөг, авлагыг насжилтаар нь харуулбал:

1. НААҮ-ний “УС-ДУ” ОНӨААТҮГ-ын 2017 оны авлагын насжилтын судалгаа

Дансны төрлөөр	Үлдэгдэл	Авлагын насжилт				
		0-3 сар	3-6 сар	6-12 сар	12-36	36-с дээш
Албан газар	11,078.5	5,539.3	3,323.6	2,215.7		
Айл өрх	38,703.7	19,351.9	11,611.1	7,740.7		
Тоолуур, ус халаагч	1,635.6	817.8	490.7	327.1		
Тоолуур, баталгаажуулалт	890.0	445.0	267.0	178.0		
Дотоодын байгууллагаас авах авлага	2,933.9	1,467.0	880.2	486.8	100.0	
Хувь хүмүүс харилцагчдаас авах авлага	10,617.4				2,827.2	7,790.2
НӨАТ авлага	29,510.7	29,510.7				
ААНОАТ-ын авлага	2,580.2	2,580.2				
Цалингийн урьдчилгаа	188.3	88.3			100.0	
Бусад авлага	466.7					466.7
Бусад урьдчилгаа	4,334.4					4,334.4
ААХ-д дараа тайлангаарх урьдчилгаа	456.9	456.9				
Нийт дүн	103,396.3	60,256.9	16,572.5	10,948.3	3,027.2	12,591.3

Хүснэгтээс харахад: Нийт авлагын 58.2% нь 0-3 сар, 16.2% нь 3-6 сар, 10.5% нь 6-12 сар, 15.1% нь 12-оос дээш сараар үүссэн авлага байна. Авлагын нийт дүнд албан байгууллагын авлага 10.7%, айл өрхийн авлага 37.4%, тоолуур, ус халаагчийн авлага 1.5%, тоолуур баталгаажилтын авлага 0.8%, байгууллагаас авах авлага 2.8%, хувь хүмүүсээс авах авлага 10.2%, НӨАТ-ын авлага 28.5%, ажиллагсадтай холбоотой бусад авлага 8.1%-ийг тус тус эзэлж байна.

2. НААҮ-ний “УС-ДУ” ОНӨААТҮГ-ын 2017 оны өр, төлбөрийн насжилтын судалгаа

Дансны нэр	Үлдэгдэл	Өр төлбөрийн насжилт				
		0-3 сар	3-6 сар	6-12 сар	12-36	36-с дээш
Дотоодын байгууллагад өгөх өглөг	0.4	0.4	-	-		
Өглөг-Айл өрх	1,154.3	-	1,154.3			
УОО	113,000.0	-	-	113,000.0		
ХХОАТ-ын өглөг	712.7	-	712.7	-		

Ажилчин албан хаагчдад өгөх өглөг	21,905.0	-	-	-	21,905.0
Хувь хүмүүст өгөх өглөг	84.0	84.0	-	-	-
Нөөц өр төлбөр	791.1	791.1			
Нийт дүн	137,647.5	75.5	1,867.0	113,000.0	- 21,905.0

Хүснэгтээс харахад: Нийт өр төлбөрийн 0.06% нь 0-3 сар, 1.3% нь 3-6 сар, 82% нь 6-12 сар, 15.9% нь 36-с дээш сараар хуримтлагдсан үүссэн өр төлбөр байна. Өр төлбөрийн дүнд 82.0% нь урьдчилж орсон орлогоор бүртгэсэн 1, 3-р байрны подваль, 15.9% нь ажилтан албан хаагчдад төлөх өр, бусад өр төлбөр 2.1%-ийг эзэлж байна.

Авлага, өр төлбөрийн бүртгэл тайлагналтай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 2016 онд 107 айл өрхийн 446.7 мянган төгрөгийн илүү төлөлтийг урьдчилж орсон орлогоор тайлагнаагүй авлага-орлого дансанд бичиж, дутуу төлсөн 23 айл, өрхийн 415.3 мянган төгрөгийн авлагыг уг төлөлтөөр хаасан байна.
- 2016 оны тоолуур баталгаажилтаас үүссэн орлогын 365.0 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлагаар тайлагнаагүй байна.
- НБББББ-т хүлээсэн үүргээ биелүүлснээр эдийн засгийн үр өгөөж буурах магадлалтай бөгөөд үр дүнг нь бодитой хэмжих боломжтой тохиолдолд өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө гэж заасан боловч 2016 онд 4,397.9 мянга, 2017 онд 363,252.1 мянган төгрөгийн орлогыг хүлээн авсан дүнгээр нь байгууллагад төлөх өр төлбөр үүсгэж бүртгэсэн байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 14.4.3, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.26-т заасныг зөрчсөн байна.

Авлага, өр төлбөртэй холбоотой нийт 368,876.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 365.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 368,511.1 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хугацаа хэтэрсэн өр, авлагыг барагдуулах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Хөрөнгийг хууль журмын дагуу бэлтгэж, үнэн зөв бүртгэж тайлагнасан эсэх

Бүлэг 3

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулаагүй, хөрөнгийн дансны ангиллыг буруу бүртгэж тайлагнасан байна.

3.1. Хөрөнгө, бараа материалын худалдан авалтыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь 2016 онд аймгийн ИТХТ-ийн 31 дүгээр тогтоолоор 44,292.3 мянга, 2017 онд 14,282.9 мянга, нийт 58,575.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан байна.

Худалдаж авсан үндсэн хөрөнгүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-ийн босго үнээс бага тул шууд худалдан авалт хийсэн байна.

Тус байгууллага нь 2016 онд 782,488.0 мянга, 2017 онд 525,771.0 мянга, нийт 1,308,259.0 мянган төгрөгийн 10 нэр, төрлийн бараа материал худалдан авсан байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь 2017 онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хавсралтаар зардлын төлөвлөгөөг батлуулсан боловч худалдан авалтын төлөвлөгөөг бараа материалын нэр, төрлөөр задалж төлөвлөөгүй байна.

2017 оны бараа материалын худалдан авалтыг төлөвлөгөө, гүйцэтгэлээр нь хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

Д/д	Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт
1	Нүүрс	296,674.8	220,386.8	76,288.0
2	Шатахуун	45,270.0	41,217.7	4,052.3
3	Сэлбэг материал, урсгал засвар	73,452.7	96,329.9	-21,885.7
4	Багаж хэрэгсэл	991.5		
5	Бичиг хэрэг	2,455.5	2,538.4	-82.9
Нийт дүн		418,844.5	360,472.8	58,371.7

Хүснэгтээс харахад. Нүүрсний зардлыг 296,674.8 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 220,386.8 мянга буюу 25.7%, шатахууны зардлыг 45,270.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 41,217.7 мянга буюу 8.9%-иар тус тус буурсан нь шинэ зуухны ашиглалтанд орох хугацаа хойшилсонтой холбоотой байна. Сэлбэг материал, урсгал засварын зардалд 74,444.2 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 96,329.9 мянган төгрөгийг зарцуулж, зардал 22.7%-иар өссөн нь төлөвлөлтөөс шалтгаалсан байна.

Худалдан авсан бараа материалыг нэр, төрлөөр нь өмнөх онтой харьцуулбал:

/мянган төгрөгөөр/

д/д	Бараа материалын нэр төрөл	2016 он	2017 он	Өсөлт, бууралт
1	Авто сэлбэг	26,759.6	10,371.5	16,388.1
2	Зуухны сэлбэг	80,328.5	48,859.8	31,468.7
3	Орон сууцны сэлбэг	165,100.2	108,017.4	57,082.8
4	Түүхий эд үндсэн материал	127,726.8	60,981.3	66,745.5
5	Хангамжийн материал	57,520.5	15,006.6	42,513.9
6	Цахилгаан сэлбэг хэрэгсэл	21,482.8	15,736.5	5,746.3
7	Хатуу түлш	260,380.3	221,287.2	39,093.1
8	Шингэн түлш	41,599.2	41,713.4	-114.2
9	Эргэлтийн сүргийн мал	1,590.0	3,255.0	-1,665.0
10	Бичиг хэргийн материал	0.0	542.1	-542.1
ДҮН		782,488.0	525,771.0	256,717.0

Хүснэгтээс харахад: 2017 оны бараа материалын худалдан авалт өмнөх оноос 32.8% буюу 256,717.0 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь хөрөнгө оруулалтын ажил буурсан, шинэ зуух ашиглалтад орж, хуучин зуухны засварын болон сэлбэг хэрэгслийн зардал буурсантай холбоотой байна.

2016, 2017 онд нүүрс болон тээвэр шатахууны худалдан авалтыг хийхдээ “Шивээ-Овоо” ХК, “Алхана Трейд” ХХК-тай гэрээ байгуулж ажилласан байна. Бусад бараа материалын худалдан авалтыг хийхдээ огт гэрээ байгуулаагүй байна.

Бараа материалын худалдан авалттай холбоотой анхан шатны баримтуудыг тулган баталгаажуулахад дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

1. Анхан шатны баримтгүй 105.0 мянга, хүчин төгөлдөр бус баримтаар 302.1 мянга, нийт 407,1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд анхан шатны баримтгүй болон хүчин төгөлдөр бус баримтаар худалдан авалт хийсэн 407.1 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Худалдан авалт хийхдээ харилцаж буй байгууллага, хувь хүнтэй худалдах худалдан авах гэрээ, хэлцэл байгуулаагүй, 564,677.9 мянган төгрөгийн худалдан авалтыг кассаас бэлэн мөнгөөр хийж гүйцэтгэсэн байна.

2016-2017 онд харьцуулалт болон нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулаагүй худалдан авалтыг хүснэгтээр харуулбал:

Д/д	Он	10 сая төгрөгөөс дээш худалдан авалтын дүн	/мянган төгрөг/ Худалдан авалтын тоо
1.	2016	254,503.8	3
2.	2017	145,777.2	2
Нийт дүн		400,281.0	5

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, аймгийн Засаг даргатай 2017 онд байгуулсан гурвалсан гэрээний 5 дугаар зүйлийн 5.8.3, 5.12 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, тайлагнах, аймаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажиллах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.2. Хөрөнгийн дансны ангиллыг буруу бүртгэж тайлагнасан байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь аймгийн ИТХТ-ийн 2016 оны 31 дүгээр тогтоолоор 507,767.9 мянга, 2017 оны 19 дүгээр тогтоол, Орон нутгийн өмчийн албаны 46 дугаар албан бичгийн дагуу 147,402.3 мянга, нийт 655,170.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод хүлээн авч бүртгэсэн бөгөөд 2016 оны 14 дүгээр тогтоолоор 143,805.8 мянга, 2017 оны 30, 53 дугаар тогтоолоор 663,876.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассан байна.

Нийт нэмэгдсэн хөрөнгийн 8.7% буюу 44,292.3 мянган төгрөгийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр худалдан авсан, 91.3% буюу 463,475.6 мянган төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө эзэлж байна.

Тус байгууллага нь 2016 онд 786,397.2 мянга, 2017 онд 589,722.2 мянган төгрөгийн бараа материалыг орлогод хүлээн авч бүртгэсэн ба 2016 онд 788,297.0 мянга, 2017 онд 594,426.8 мянган төгрөгийн бараа материалыг зарлагаар бүртгэсэн байна.

Тус байгууллагын үндсэн хөрөнгийн 2016-2017 оны үлдэгдэлд хийсэн шинжилгээг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

Үзүүлэлтүүд		2017 он		Харь- цуулалт
Үндсэн хөрөнгийн хувийн жин /оны эхэнд, эцэст/	Оны эхэнд=Нийт үндсэн хөрөнгийн өртөг/Балансын цэвэр дүн	2,267.6	2,446.6	0.92
	Оны эцэст=Нийт үндсэн хөрөнгийн өртөг/Балансын цэвэр дүн	1,820.4	2,057.5	0.88
Үндсэн хөрөнгийн элэгдлийн коэффициент	Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл/Үндсэн хөрөнгийн балансын өртөг	1,422.4	3,244.6	0.43
Үндсэн хөрөнгийн шинэчлэлт коэффициент	Тайлант хугацаанд шинээр ашиглалтанд орсон үндсэн хөрөнгийн анхны өртөг / Тайлант хугацааны эцэст байгаа үндсэн хөрөнгийн анхны өртөг	147.4	3,244.6	0.045
Үндсэн хөрөнгийн хасагдалтын коэффициент	Тайлант хугацаанд ашиглалтаас хассан үндсэн хөрөнгийн анхны өртөг/Тайлант хугацааны эхэнд байгаа үндсэн хөрөнгийн анхны өртөг	663.9	3,761.1	0.17

- Үндсэн хөрөнгийн хувийн жин /оны эхэнд, эцэст: 2016 онд нийт балансын дүнгийн 92 хувийг нь үндсэн хөрөнгө эзэлж байсан бол 2017 онд 88%-ийг эзэлж байна. Энэ нь 2017 онд 663.8 сая төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой юм. Цаашид ашиглагдахгүй элэгдэл нь дууссан хөрөнгүүдийг актлах, ашиглагдахгүй хугацаа нь дуусаагүй хөрөнгүүдийг эргэлтэнд оруулах шаардлагатай юм.
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн коэффициент: Нийт үндсэн хөрөнгийн 43.8%-д нь элэгдлээ нөхсөн хөрөнгүүд байна.
- Үндсэн хөрөнгийн шинэчлэлтийн коэффициент: Нийт үндсэн хөрөнгийн 4.5% нь шинээр ашиглалтанд орсон хөрөнгүүд байна.
- Үндсэн хөрөнгийн хасагдалтын коэффициент: Нийт үндсэн хөрөнгийн 17.6% нь ашиглалтаас хасагдсан байна.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор тогтоосон боловч уг тогтоол хүчингүй болсонтой холбоотой Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу ашиглалтын хугацааг тогтоосон байна. Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох шулуун шугамын аргаар хөрөнгийн ашиглахаар тооцсон хугацааных нь туршид тогтмол хэмжээтэй элэгдэл тооцдог. Нийт үндсэн хөрөнгийн 43.8% нь хуримтлагдсан элэгдэл эзэлж байна. Элэгдлээ нөхсөн 46 нэр төрлийн 128,838.3 мянган төгрөгийн хөрөнгийг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Бараа материалын бүртгэл тайлагналтай холбоотой орлого зарлагын баримт, шаардах хуудас, агуулахын бүртгэл, шатахуун, материалын зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудас, тооцоо бодсон баримтуудыг хийж хэвшсэн байна. Уурын зуухны галлах стандарт нь сараасаа шалтгаалан нэг цагт 0.3-0.8 кг нүүрсийг тооцож олгодог байна. 2016 онд 8,929.6 кг, 2017 онд 9,089.2 кг нүүрсийг зарцуулсан байна. Баримтуудыг архивын стандартын дагуу үдэж цэгцлээгүй, дугаарлаагүй, эмх цэгцгүй байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэлд хийсэн түүвэр тооллогоор бүртгэл, тайлагналтай холбоотой дараах зөрчил дутагдлууд илэрлээ. Үүнд:

1. Хөрөнгийн хөдөлгөөн хийхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг баримталсан боловч данснаас хассан 807,682.3 мянган төгрөгийн хөрөнгийн устгалын актыг үйлдээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмын 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд данснаас хассан хөрөнгийг цэгцэлж, устгалын актыг үйлдэх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2. Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо хөрөнгийг ашиглалтад орсон өдрөөс нь тооцоогүйгээс элэгдлийг 17,145.5 мянган төгрөгөөр илүү, 30,690.2 мянган төгрөгөөр дутуу тооцож, нийт 13,544.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, НББОУС-16 заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд зөрүүтэй тайлагнасан 13,544.7 мянган төгрөгийн элэгдлээс 7,050.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг залруулах тухай албан шаардлага, 20,595.5 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3. 7 нэр, төрлийн 12,239.9 мянган төгрөгийн хөрөнгийг дансны ангиллын дагуу үнэн зөв бүртгэж тайлагнаагүй байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/				
Д/д	Хөрөнгийн нэр	Үнэ	Бүртгэсэн данс	Бүртгэх данс
1.	Тэрэгтийн камер	7,000.0	Эд хогшил	Тоног төхөөрөмж
2.	Принтер	270.0	Эд хогшил	Тоног төхөөрөмж
3.	Хурлын ширээ	1,935.7	Бараа материал	Эд хогшил
4.	Хурлын залны сандал	1,161.5	Бараа материал	Эд хогшил
5.	Буйдан	841.6	Бараа материал	Эд хогшил
6.	Босс сандал	757.6	Бараа материал	Эд хогшил
7.	Жижиг ширээ	273.5	Бараа материал	Эд хогшил

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, НББОУС-16 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд 12,239.9 мянган төгрөгийн хөрөнгийг дансны ангиллын дагуу үнэн зөв бүртгэж тайлагнах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4. Шинэ уурын зуух ашиглалтанд орсонтой холбоотойгоор 266,832.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 5,041.9 мянган төгрөгийн бараа материал /3,078.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 1,963.1 мянган төгрөгийн химийн хор/ ашиглалтгүй болсон байна.
5. Тус байгууллагын өмч хөрөнгө эмх цэгцгүй, хөрөнгийг коджуулах паспортжуулах ажил хангалтгүй байна.

3.3 Өмч хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлэх, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.

2017 оны жилийн эцсийн тайлангаар бараа материалын 7 дансанд 84,103.5 мянга, үндсэн хөрөнгийн 7 дансанд 1,822,173.2 мянган төгрөгийн нийт 1,906,276.7 мянган төгрөгийн бараа материал болон үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Байгууллагын захирлын тушаалаар 2016, 2017 оны жилийн эцсийн тооллогын комиссыг 9 хүний бүрэлдэхүүнтэй томилон тооллогыг зохион байгуулж, Өмч хамгаалах зөвлөл тооллогын комиссын дүгнэлтийг үндэслэн бараа материалыг актлах, шилжүүлэх саналыг гаргаж, үндсэн хөрөнгийн орлогод авах, актлах, шилжүүлэх саналыг Орон нутгийн Өмчийн газарт хүргүүлж хэвшсэн байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-т нийт 3,244,588.2 мянган төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас 2,977,755.5 мянга буюу 91,8% нь үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглагдаж, 266,832.7 мянган төгрөгийн хөрөнгө буюу 8.2% нь ашиглагдаагүй хөрөнгө байна.

Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдлыг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Хими цэвэрлэгээний тоног төхөөрөмж 26,201.1 мянга, Сүмбэрийн халуун усны барилга 20,631.6 мянга, нийт 46,832.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө ашиглалтгүй, он удаан жил хадгалагдаж байна.
- Шинэ хорооллын шугам буюу “Эко Сүмбэр” хотхоны 220,000.0 мянган төгрөгийн шугам нь “Ус-Ду” ОНӨААТҮГ-т хамааралгүй байхад Орон нутгийн Өмчийн албаны 2012 оны 77 дугаартай тоотын дагуу үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусган элэгдэл тооцсон байна.
- Шинэ зуух ашиглалтанд орсонтой холбоотойгоор 3,078.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 1,963.1 мянган төгрөгийн химийн хор, нийт 5,041.9 мянган төгрөгийн бараа материал ашиглалтгүй болсон.
- Данснаас хассан хөрөнгийг акт үйлдэж устгаагүйгээс хөрөнгийг их хэмжээгээр хуримтлуулан хадгалсан.
- Хөрөнгө хадгалж буй агуулах, өрөө тасалгааны эмх цэгц муу, хөдөлмөр хамгааллын хувцасыг ашиглалтын хугацаа дуусаагүй байхад шаардахаар зарлагдсан.

Эдгээр зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 26 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Цаашид ашиглалтгүй байгаа хөрөнгүүдийг эргэлтэнд оруулах буюу худалдан борлуулах, өмч хөрөнгийн эмх цэгцийг сайжруулж коджуулах арга хэмжээг авах тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Дотоод хяналт үр дүнтэй эсэх

Бүлэг 4

Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй, хяналтын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

4.1. Байгууллагын удирдлага дотоод хяналтын үүргээ хэрэгжүүлээгүй байна.

“Ус Ду” ОНӨААТҮГ-ын захирлын 2016 оны А/61 дугаартай тушаалаар “Дотоод хяналт, шалгалтын журам”-ыг шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна. Тус журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эдийн засагч, дотоод аудит, төсөл, тендер хариуцсан ажилтанд дээрх тушаалаар үүрэг болгосон байна.

2016 онд дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө гаргаагүй, 2017 онд 8 хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Борлуулалтын хэсгийн үйл ажиллагаанд хяналт хийх
- Хэрэглэгчдээс ирсэн дуудлага, санал, гомдлын мөрөөр ажиллах
- Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн, хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчны хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийх
- Хүний нөөц, бичиг хэргийн ажилтны бичиг баримтын бүрдүүлэлтэнд хяналт шалгалт хийх
- Хяналтын камерын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих
- Худаг, худгийн тоног төхөөрөмж, техник ашиглалтын паспорт хөтлөлт шалгах
- 2015, 2016, 2017 онуудын санхүүгийн баримтуудын иж бүрдлийг шалгах
- Тушаал, шийдвэр, албан даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтэнд тавих хяналт

2016 онд нийт 2 удаагийн хяналт шалгалт хийгдсэн ба “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчны хэрэгжилтийн байдал” “Борлуулалтын хэсгийн үйл ажиллагаа”-нд хяналт шалгалт хийсэн байна. Тус хяналт шалгалтаар доорх зөвлөмжүүдийг өгсөн байна.

- Мэргэжлийн байгууллагаар сууцны талбайн хэмжилтийг хийлгэх
- Айл өрхийн бичилтийг сар бүр бичиж, үлдэгдлээ баталгаажуулах
- Айл өрхүүдтэй гэрээ байгуулах, гэрээний дүгнэлтийг хавсаргах

2017 онд төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулаагүй бөгөөд удирдлагын зүгээс өөрийн баталсан төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

2017 онд “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчны хэрэгжилтийн байдлын хяналт шалгалт”-ыг удирдамжийн дагуу 1 удаа хийсэн ба энэ нь төлөвлөснөөс 12.5%-ийн хэрэгжилттэй байна. Тус шалгалтаар доорх зөвлөмжүүдийг өгсөн байна:

- Ажилтнуудыг ажлын нормын хувцсаар тогтмол хангах
- Бүх ажилчдыг аарцанд хамруулах

Тус байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотой төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулаагүй, хяналт шалгалтын дүн, авсан арга хэмжээний талаар удирдлага, хамт олонд мэдээлээгүй, хяналт шалгалтын мөрөөр зөрчил дутагдлыг засч залруулах арга хэмжээ аваагүй зэрэг зөрчлүүд илэрлээ

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311-р тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг зөрчиж байна.

Иймд дээрх журмыг хэрэгжилтийг хангаж, байгууллагын үйл ажиллагааны бүх чиглэлийг хамарсан дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөний дагуу ажил үүргээ чанартай гүйцэтгэх, удирдлагын зүгээс дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахад анхаарах, дотоод хяналтын нэгж, ажилтны ажил үүргийг тодорхой болгох талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Хөдөлмөр, хамгаалал, эрүүл ахуйн чиглэлээр хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөө хангалтгүй байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын хөдөлмөр хамгаалал хариуцсан ажилтнаар 2016 оны 03 сар хүртэл Ж.Отгонбилэг ажилласан бөгөөд 2016 оны 8 сард Б/64 тоот тушаалаар Д.Тунамал-Эрдэнийг томилсон байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын захирлын 2016 оны А/70 дугаартай тушаалаар “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийн дүрэм”, “Аюулгүй ажиллагааны ерөнхий дүрэм”, “Хувийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны олголт ба ашиглалтын журам”, “Гамшгаас хамгаалах арга хэмжээ зохион байгуулах журам”, “Харуул хамгаалалт хариуцсан ажилтны ажиллах журам”-ыг тус тус баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус байгууллага нь 2016-2017 онд ажилтан, албан хаагчдыг эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2 удаа хамруулсан байна.

Тус байгууллага нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлаар талаар 2016 онд 37, 2017 онд 42 сургалт зохион байгуулахаар төлөвлөжээ.

2016, 2017 онд зохион байгуулсан сургалтуудыг хүснэгтээр харуулбал:

Он	Сургалтын нэр	Хамрагдсан хүний тоо	Гүйцэтгэлийн хувь
2016 онд 37 сургалт төлөвлөсөн	Машин механизм, тоног төхөөрөмжид тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага	36	8 сургалт буюу 21.6% зохион байгуулагдсан
	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй-2 удаа	36	
	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тухай ойлголт	36	
	Цахилгаан тоноглолыг хамгаалах арга хэмжээ	36	
	Захирлын А/70 тушаал танилцуулах сургалт	36	
	Зуух галлах үеийн аюулгүй ажиллагаа	5	
	Ажлын байранд галын аюулгүй байдал	31	
	Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хуулиуд-2 удаа	37	

2017 онд 42 сургалт төлөвлөсөн	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	31	5 сургалт буюу 11.9% зохион байгуулагдсан
	Архи тамхины хор хөнөөл	24	
	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ	32	

Хүснэгтээс харахад: Сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулаагүйгээс хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал: Төлөвлөсөн сургалтууд 2016 онд 21.6%, 2017 онд 11.9%-ийн гүйцэтгэлтэй байна.

Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн чиглэлээр 2016, 2017 онд олгосон зардлыг төлөвлөгөө, гүйцэтгэлээр нь хүснэгтээр харуулбал:

Д/Д	Материалын нэр	Хэмжих нэгж	2016 он			2017 он		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Нормын хувцас /Өвөл, зун /	ш	66	43	33	69	64	5
2	Гутал /Өвөл, зун/	ш	30	-	30	52	-	52
3	Усны гутал	ш	-	8	-8	9	6	6
4	Бээлий	ш	500	311	189	462	363	75
5	Хошуувч	ш	50	45	5	141	63	78
6	Хор саармагжуулах аарц	кг	150 кг	179.7 кг	-29.7	742.5кг	179.7 кг	562.8
7	Каск	ш	30	39	-9	15	6	9
8	Нүдний шил	ш	50	11	50	15	9	6
9	Витамин	уут	-	-		324	82	-

Хүснэгтээс харахад: Хөдөлмөр хамгааллын материалын зардалд 2016 онд 11,725.0 мянган төгрөгийн 9 нэр төрлийн бүтээгдэхүүн олгохоор төлөвлөснөөс 6,098.2 мянган төгрөгийн 7 төрөл, 2017 онд 11,542.4 мянган төгрөгийн 10 нэр төрлийн бүтээгдэхүүн олгохоор төлөвлөснөөс 8 төрлийн 7,469.2 мянган төгрөгийн хөдөлмөр хамгааллын бүтээгдэхүүн, холбогдох материалыг олгосон нь өмнөх оноос 18.3%-иар өссөн байна.

Тухайлбал: 2016 онд хор саармагжуулах аарц 150 кг төлөвлөж, олгосон нь 179.7 кг буюу 20%-иар өссөн, 2017 онд хор саармагжуулах аарц 742.5 кг төлөвлөснөөс олгосон нь 179.7 кг буюу 24.2%-иар буурсан, витамин 324.2 гр уутыг төлөвлөснөөс 113 гр уутыг олгосон байна.

2016 онд Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн чиглэлээр хийгдэх 6 ажилд 9,700.0 мянган төгрөг төлөвлөснөөс 7,997.5 мянга буюу 81.5%, 2017 онд 20 ажилд 15,000.0 мянга төлөвлөснөөс 11,823.5 мянга буюу 78.6%-ийг зарцуулсан байна. 2017 онд өмнөх оноос сургалт, онцгой байдлын үеийн бэлэн байдал зэрэг ажлууд нэмэгдэж, төлөвлөгөө 35.3%-иар өссөн ба гүйцэтгэл тайлант онд 8.6 %-тай боловч өмнөх оноос 32.3%-иар өсчээ.

Цаашид хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн чиглэлээр хийх ажлыг тодорхой болгох, холбогдох зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөх, гүйцэтгэлийг тооцож ажиллах, үр дүнтэй зохион байгуулах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

4.2. Дотоод хяналт үр дүнгүй байна.

“УС-ДУ” ОНӨААТҮГ нь “Дотоод хяналт, шалгалтын журам”-ын дагуу жилийн хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө батлуулж байгаа боловч уг төлөвлөгөө нь байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь хамруулах чиглэл тусгаагүй байна.

2016 онд дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө гаргаагүй, 2017 онд 8 хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн боловч 2016 онд 2, 2017 онд 1 хяналт шалгалт хийж хэрэгжилт нь 12.5%-тай байна. Дотоод хяналт, шалгалтын нэгж ажилтан нь хяналт шалгалтын дүн, авсан арга хэмжээний талаар удирдлага болон хамт олонд улирал тутам

мэдээлэл хийх ёстой боловч огт мэдээлэл хийгээгүй, илрүүлсэн зөрчлийг арилгах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Дотоод хяналтын нэгж, ажилтны үүргийг эдийн засагч, дотоод аудит, төсөл, тендер хариуцсан ажилтанд үүрэг болгосон нь бусад бүтэц, нэгжээс хараат бус байх зарчмыг алдагдуулсан, давхар хариуцсан ажлыг ажлын байрны тодорхойлолтонд оруулаагүй зэрэг зөрчлүүд илэрч байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311-р тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг зөрчиж байна.

Иймд дээрх журмыг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.3. Бусад байгууллагаас хийгдсэн хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-т 2016 онд Татварын хэлтсээс “Татвар ногдуулалт, төлөлт”, 2017 онд аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ үнэлгээний тасгаас 2016 оны үйл ажиллагаанд, Мэргэжлийн хяналтын газраас “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Нийгмийн даатгалын тухай”, “Хөдөлмөрийн тухай” хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилт, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсээс төлөвлөгөөт хяналт шалгалтууд хийгджээ.

Хяналт шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчлүүдийг дурьдвал:

- 2012-2015 онд НӨАТ-ын тайлангаар ногдуулсан албан татварыг хуульд заасан хугацаанд төсөвт төлөөгүй.
- Ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллагсадад олгосон цалин хөлсний орлогод шимтгэл тооцоогүй, бүрэн хамруулаагүй.
- Улирлын шинж чанартай ажиллаж буй ажилтнуудын ажиллаагүй хугацааны шимтгэлийг төлөөгүй.
- Ажилтнуудад олгосон цалин хөлс, шагнал урамшуулал, түлээ нүүрсний хөнгөлөлт зэргээс шимтгэл тооцоогүй.
- Нийт ажилтнуудын дэвтэрт бүрэн бичилт хийж, баталгаажуулаагүй.
- Ажилтнуудын хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг зөрүүтэй тооцсон.
- Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам баталж, төлөвлөгөө гарган ажиллаж байгаа хэдий ч үйл ажиллагааг бүхэлд нь хамруулахаар тусгаагүй, нэгж ажилтанг томилоогүй, илрүүлсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллаагүй.

Татварын хэлтсийн хяналт шалгалтаар 4,698.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, Мэргэжлийн хяналтын газрын шалгалтаар нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, дотоод хяналттай холбоотой зөрчлүүдэд 12 зөвлөмж өгсөн ба 2,149.5 мянган төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх зөрчил, төлбөрийн акт тогтоосон байна.

“Ус Ду” ОНӨААТҮГ нь дээрх байгууллагуудаас өгсөн төлбөрийн актыг тогтоосон хугацаанд төвлөрүүлж, зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн боловч зөвлөмжийн дагуу хийх ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

Цаашид хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тооцож ажиллах, алдааг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

4.4. Шилэн дансны цахим системд оруулсан мэдээний 61.5% нь хугацаа хоцорсон мэдээлэл байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу Шилэн дансны цахим нэгдсэн хуудсанд 2016, 2017 онд тус тус 146 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

“Ус Ду” ОНӨААТҮГ-ын Шилэн дансны цахим нэгдсэн хуудсанд мэдээлэл оруулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

2016 онд				
Д/Д	Шилэн дансны мэдээллийн нэр төрөл	Нийт оруулах мэдээлэл	Хугацаандаа оруулсан	Хугацаа хоцроосон
1	Төсөв, гүйцэтгэл	46	4	42
2	Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт	39	1	38
3	Бусад	61	0	61
Нийт		146	5	141
2017 онд				
1	Төсөв, гүйцэтгэл	43	24	19
2	Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт	39	23	16
3	Бусад	61	41	20
Нийт		146	88	55

Хүснэгтээс харахад: холбогдох мэдээллийг бүрэн мэдээлсэн боловч 2016 онд 96.6% буюу 141 мэдээлэл, 2017 онд 61.5% буюу 55 мэдээллийн хугацаа хоцорсон төлөвтэй байна. Энэ нь мэдээллийг хуульд заасан хугацаанд тухай бүр мэдээлээгүйтэй холбоотой байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил дутагдлууд илэрлээ. Үүнд:

1. 2016 онд 141, 2017 онд 55 мэдээллийн хугацаа хоцорсон төлөвтэй
2. 2016 онд 44, 2017 онд 28 тушаал шийдвэр гарснаас нэг ч тушаал, шийдвэр байршуулаагүй
3. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг дээр огт мэдээлэл оруулаагүй
4. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр, гүйлгээний агуулга хүлээн авагчийн нэр мэдээлэл оруулахыг гүйлгээ бүрээр шивж оруулаагүй, зөвхөн файлууд хавсаргасан
5. Байгууллага өөрийн цахим хуудасгүйгээс ил тод нээлттэй мэдээлээгүй.

Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5, 6.4.8 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 2,030,192.0 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлснээс 985.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 22,290.7 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 2,006,576.0 мянган төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

ДУГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

- Байгууллага үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Техник тоног төхөөрөмж, технологийн шинэчлэл хийгдээгүй улмаас үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар хангалтгүй байна. Байгууллагыг үүсгэн байгуулсан баримт бичиг болох компанийн дүрмийг шинэчлэн батлуулах, үйлдвэрлэлийн төлөвлөгөө гаргаж ажиллах, хэрэглэгчидтэй гэрээ байгуулан, дүгнэх, байгууллагын үйл ажиллагааны талаар орон нутгаас баримтлах бодлогын баримт бичиг боловсруулж ажиллах шаардлагатай байна.
- Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг үйл ажиллагааны чиглэлээр нь орон тоотойгоо уялдуулан тодорхойлоогүй, бүтэц, зохион байгуулалтын схемд үндсэн чиг үүргийг гүйцэтгэж буй алба хэсгийг тусгаагүй, бүтэц, зохион байгуулалтын схем ойлгомжгүй, оновчтой бус байна.
- Хүний нөөц, боловсон хүчний бодлого төлөвлөлт хангалтгүй, ажиллагсдын ажлын гүйцэтгэлийг ажлын үр дүнтэй уялдуулан тооцдоггүй, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлаагүй, хувийн хэргийн бүрдэл хангалтгүй, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, ажилчдын цалин хөлс, нийгмийн баталгаа хангагдаагүй байна.
- Байгууллага орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд алдагдлыг бууруулж ажилласан байна.

Бүлэг-2

- Үндсэн үйл ажиллагааны орлого, зардлын төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөсөн нь бодит байдалтай нийцээгүй байна.
- Орлогыг бүрэн бүрдүүлж, үнэн зөв бүртгээгүй, зардлыг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна.
- Дараа тайлангийн журмыг шинэчлэн боловсруулах, мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж хяналт тавих эрх бүхий этгээдүүд хөрөнгө бэлтгэхгүй байх, мэдээлэл технологи, цахим төлбөр тооцооны системд шилжин ажиллах шаардлагатай байна.
- Үнэ, тарифыг бүтээгдэхүүний өртөг, хэрэглэгчдийн төлбөрийн чадварт үндэслэн зохистой хэмжээнд тогтоох, өртгийг үнэн зөв тооцож, тайлагнах шаардлагатай байна.
- Өр, авлагыг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулаагүй, үнэн зөв бүртгэж тайлагнаагүй, хугацаа хэтэрсэн авлага, өр төлбөрийг барагдуулах талаар идэвхи санаачлагатай ажиллаагүй байна.

Бүлэг-3

- Хөрөнгө, бараа материалын худалдан авалтыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.
- Өмч, хөрөнгийг хууль журмын дагуу үнэн зөв бүртгээгүй байна.
- Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй, эмх цэгцгүй байна.
- Хөрөнгийг коджуулж, агуулахын эмх, цэгцийг сайжруулах шаардлагатай байна.
- Акталж данснаас хассан хөрөнгийн устгалын актыг үйлдээгүй байна.

Бүлэг-4

- Байгууллагын удирдлага дотоод хяналтын үүргээ хэрэгжүүлээгүй байна.
- Хөдөлмөр, хамгаалал, эрүүл ахуйн чиглэлээр хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөө хангалтгүй байна.
- Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.
- Шилэн дансны цахим системд оруулсан мэдээний 61.5% нь хугацаа хоцорсон мэдээлэл байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын даргад:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-т заасны дагуу жил бүр тус байгууллагын үйл ажиллагааг хэлэлцэн, үнэлэлт, дүгнэлт өгөх

Аймгийн Засаг даргад:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу жил бүр гэрээ байгуулан, үйл ажиллагаа, үйлдвэрлэл, санхүүгийн ашиг, алдагдлын төлөвлөгөөг баталж ажиллах
2. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т заасны дагуу төсөл, хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах
3. Компанийн дүрмийг шинэчлэн батлах

“УС-ДУ” ОНӨААТҮГ-ын Захирал Б.Ганзоригт:

1. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиг үүргийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай бодлогын баримт бичгийг боловсруулах, Компанийн дүрмийг шинэчлэн боловсруулж батлуулах
2. Бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн төлөвлөгөө батлуулж, мөрдөх, орлого, зардлыг бодитой төлөвлөх, айл өрхтэй 100% гэрээ байгуулж дүгнэх, айл өрхийн талбайн хэмжээг бодитой тогтоох
3. Хэрэглээний халуун ус, дулааны үнэ тарифыг хэрэглэгчдийн орлого, үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг харгалзан зохистой хэмжээнд шинэчлэн батлуулах
4. Орон тоо, цалингийн зардлыг бодитой төлөвлөж батлуулах, зардлыг хэтрүүлэхгүй байх жилийн дундуур зардал нэмэгдүүлэх шийдвэр гаргахгүй байх
5. Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Загвар, зааврыг батлах тухай” тогтоол, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар заалтыг мөрдөж ажиллах, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, үндсэн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай боловсон хүчин бэлтгэх, ажиллагсдын ажлын гүйцэтгэлийг сайжруулах
6. Бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, бүтээгдэхүүний өртөгт шингээж буй зардлыг үнэн зөв тооцож бүртгэх, борлуулалтын дэвтрийг сар бүр хянан тооцоо

- нийлсэн актаар баталгаажуулах, НБББББ-ийг хянаж, алдаатай заалтуудыг залруулах, байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэх,
7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, тайлагнах,
 8. Ашиглалтгүй худгийг шугаманд холбох, нөөц усан сан барих, төмөргүйжүүлэх төхөөрөмжийг шинэчилж чанар стандартад нийцсэн ундны усаар хэрэглэгчдийг хангах ажлыг зохион байгуулах
 9. Дараа тайлангийн журмыг шинэчлэн боловсруулах, бэлэн мөнгөний зарцуулалтанд хяналт тавих эрх бүхий этгээдүүд дараа тайлангаар материал бэлтгэхгүй байх, мэдээлэл технологийн шинэчлэл, цахим сүлжээг ашиглан худалдан авалтыг дансаар хийж гүйцэтгэх, цахим төлбөр тооцооны хэрэгслийг ашиглах, уламжлалт арга барилаас салах, мөнгөн хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах
 10. Хугацаа хэтэрсэн өр, авлагыг барагдуулах
 11. Ашиглалтгүй байгаа хөрөнгүүдийг эргэлтэнд оруулах буюу худалдан борлуулах, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, агуулахын эмх цэгцийг сайжруулж, хөрөнгийг үнэн зөв коджуулах арга хэмжээг авах
 12. Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн чиглэлээр хийх ажлыг бодитой төлөвлөх, гүйцэтгэлийг тооцож ажиллах, сургалтуудыг зөв төлөвлөх, үр дүнтэй зохион байгуулах
 13. Дотоод хяналт, шалгалт хариуцсан ажилтны хийх ажлыг ажлын байрны тодорхойлолт болон ажлын төлөвлөгөөнд оруулж тодорхой болгох, дотоод хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчлийг ажилчдад танилцуулах, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч ажиллах, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах
 14. Байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хамааралгүй, зардлыг нэмэгдүүлж, байгууллага алдагдалтай ажиллахад нөлөөлж буй “Эко сүмбэр” хотхоны шинэ хорооллын 220,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий шугамын эзэмшлийн асуудлыг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх
 15. Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тооцож ажиллах, алдааг давтан гаргахгүй байх

Аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлд:

- Хэрэглээний халуун ус, дулааны үнэ тарифыг хэрэглэгчдийн орлого, үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртгийг харгалзан зохистой хэмжээнд шинэчлэн тогтоох

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙТИЙН АЖ АХУЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ “УС-ДУ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ
АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

42010 Чойр, Говьсүмбэр аймаг, Утас: 7054-3270

2019-06-08 № 128

танай _____ -ны № _____

Г ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН Г
АУДИТЫН ГАЗАРТ

Гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал
хүргүүлэв.

Хүлээн авч шийдвэрлэж өгнө үү.

Хавсралт: Гүйцэтгэлийн аудитын тайланд өгөх санал

ЗАХИРАЛ  Б.ГАНЗОРИГ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

2018.06.04.

1. 7-р хуудас : Тус байгууллагаар үйлчлүүлдэг 1119 айл өрхийн 6,6 хувь буюу 7 айл өрхтэй гэрээ байгуулаагүй, 67 айл өрхийн гэрээг сунгаагүй байна. Гэж оруулах ✓

2. 21-р хуудас: ... хөрөнгө оруулалтын ажлыг бүрэн төлөвлөгүйгээс 2016 оны төлөвлөгөөнөөс орлого 476,9 сая төгрөгөөр, зардал 440,8 сая төгрөгөөр нэмэгдэн үндэслэлгүй төлөвлөсөн байна. Гэж "Голден пейж" аудитын газраас зөвлөсний дагуу 2017 оны төлөвлөгөөнд тусгай зөвшөөрлийн хүрээнд хийх ажлуудыг төлөвлөн оруулсан болно. X

3. 26-р хуудас, 35-р хуудас: үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг илүү, дутуу тооцсон тооцооллыг харахад 2016, 2017 онуудад зөрүү байхгүй байгаа ба анх ашиглалтанд орсоноос хойш тасралтгүй элэгдлийг байгуулахаар тооцон зөрүүг гаргасан байна. Бид жил бүр санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудит, 2-4 жил тутам гүйцэтгэл, нийцлийн аудит, мэргэжлийн хяналтын санхүүгийн аудитаар орж шалгагдаж байсан ба тухайн үеийн шалгалтуудаар үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу, илүү байгуулсан талаар зөрчил илрэхгүй байсан. ✓

Шинэ хорооллын шугам 220,0 сая төгрөгийн шугам хоолой нь 2012 онд барьж байгуулан данс бүртгэлд тусгасан боловч 2015 оноос ашиглаж эхэлсэн ба ашиглаж эхэлсэнээс хойш элэгдэл тооцсон. Зөрчлийн нэгтгэл дээр элэгдэл дутуу тооцсон 20952,4 мянган төгрөг, элэгдэл тооцсон 31428,6 мянган төгрөг гэж 2 өөр утгаар орсон байна. Үүнийг нэгтгэн ашиглалтгүй байгаа хөрөнгө 220000,0 төгрөгийн шинэ хорооллын шугам хоолой, дундын өмчлөлийн эд хөрөнгө болох 1,3-р байрны подвалийн шугам хоолой 120000,0 сая төгрөг, халуун усны барилга, тоног төхөөрөмжийн бүртгэлийг шилжүүлэхийг аймгийн Засаг дарга, АИТХ-д хүргүүлэх саналд нэмж оруулах саналтай байна.

Усны халаалтын DZL-2,8 тогоо нь 2006 онд ашиглалтанд орсон ба 2009 он хүртэл хэрэглээний халуун усыг тусгай жижиг зуухаар өгдөг байсан тул уг 3 жилийн халаалтгүй 15 сарын элэгдэл тооцоогүй болно.

4. Зөрчлийн нэгтгэлээс ажилчдаас суутган авсан хоолны мөнгөөр худалдан авсан махны үнэ, Манжуурт тушаалаар шагналын журмаар явсан 8 хүний 3,0 сая төгрөгийг хасуулах саналтай байна. Махны үнэнд ажилчдаас суутгасан урьдчилгааны журнал, эргүүлж тушаасан баримт, Манжуурын аялалын хөтөлбөр, Манжуурт аяласан зураг, гадаад паспортын орсон гарсан гаалийн тэмдэглэл зэргийг хавсаргав.

Ерөнхий нягтлан бдогч *У.Батдолгор* У.Батдолгор



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

“УС-ДУ” ОНӨААТҮГ-аас ирүүлсэн саналтай танилцаад дараах тайлбарыг өгч байна.

Тайлбар 1:

Саналтай танилцаад тайланд “Тус байгууллагын нийт хэрэглэгчийн 75%-ийг 1,119 айл өрх эзэлж байгаа боловч 7 айл өрхтэй гэрээ байгуулаагүй, 67 айл өрхийн гэрээг сунгаагүй, хэрэглэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж ажиллаагүй, айл өрхийн халаалтын талбайг бодитой тооцож гаргаагүй байна” гэж өөрчлөлт оруулав.

Тайлбар 2:

Саналтай танилцаад өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлбар 3:

Санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагад оршин буй бүх эрсдэл, алдаа зөрчлийг илрүүлэх боломжгүй бөгөөд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлсний үндсэн дээр дээрх алдаа зөрчлүүд илэрсэн тул уг хэсэгт бүхэлд нь өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ. “Эко сүмбэр” хотхоны шинэ хорооллын шугамын элэгдэл 20,952.4 мянган төгрөг зөрчлийн нэгтгэлд давхардсаныг зөрчлөөс хасч өөрчлөлт оруулав.

Тайлбар 4:

Саналыг хянаж үзээд махны төлбөрт тавигдсан 1,424.8 мянган төгрөгийг касст буцаан тушаасан, салхивчны ажлын дутуу 260,0 мянган төгрөг гэрээгээр нотлогдсон тул төлбөрийн актаас хасч, Манжуурын аялалын 3,000.0 мянга, томилолтын удирдамж тайлангүй 300.0 мянга, нийт 3,300.0 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгаж тайлагнасан, нягтлан бодогчийн үүргээ зөрчиж, ажилдаа хариуцлагагүй хандсан ерөнхий нягтлан бодогч У.Батдолгорт хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр өөрчлөлт оруулав.